

**Өвлөгдөх хөрөнгийг гэрээний үндсэн дээр
хуваарилах эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх нь**

**Reforming the Legal Framework of Contractual Distribution
of Inheritance Property**

Эрдэнэбатын Отгонтамир

Хууль зүйн ухааны бакалавр (LL.B.)

Улаанбаатар хот, Монгол Улс.

otgontamir.erdenebat@gmail.com

© E.Otgontamir, 2025



[Attribution-NonCommercial 4.0 International
\(CC BY-NC 4.0\)](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)

[Товч утга]

Монгол Улс 1992 оны Үндсэн хуулиар өмчийн эрхийг тунхаглаж, түүнтэй холбогдох өв залгамжлал бодитоор хэрэгжих эрх зүйн зохицуулалтыг 2002 онд Иргэний хуульд тусган өгч, түүнээс хойш ямар нэгэн нэмэлт, өөрчлөлтгүйгээр өнөөдрийг хүрчээ. Манай улс хуульд зааснаар болон гэрээслэлээр өвлөгдөх хөрөнгийг хуваарилах аргыг Иргэний хуульд хуульчилж өгсөн ба хууль ёсны өвлөгчид өвлөгдөх хөрөнгийг гэрээний үндсэн дээр хуваарилах эрхийг нээлттэй байдлаар зохицуулсан.

Өвлөгдөх хөрөнгийг гэрээгээр хуваарилах харилцаа нь хууль ёсны өвлөгчид өөр хоорондоо харилцан тохиролцож өв хөрөнгийн биет байдал, өнөөгийн болон ирээдүйд олох үр шим, үр ашгийг харгалзан үзсэний үндсэн дээр түүний үнэ цэнийг алдагдуулахгүйгээр хуваах, хуваарилан авахтай холбогдсон харилцааг зохицуулах юм. Энэ асуудлаар тусгайлан судалсан бүтээл байхгүй тул иргэний эрх зүй болон өв залгамжлалын эрх зүйн онол, үзэл баримтлал, судлаачдын дэвшүүлсэн санал, Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон Улсын өв хөрөнгийг харилцан тохиролцож хуваарилдаг туршлагыг харьцуулан судалсны үндсэн дээр Өвлөгдөх хөрөнгийг гэрээгээр хуваарилах аргыг дэвшүүлэв.

Түүнчлэн өв залгамжлалын харилцаанд өв хөрөнгийн үнэ цэнийг хадгалах, хамгаалах замаар шилжүүлэхтэй холбогдсон Бүгд Найрамдах Франц Улсын туршлагыг судлан өвлөгдөх хөрөнгийг гэрээгээр хуваарилах харилцаанд хэрэгжүүлэх боломжийг энэхүү өгүүллээр гаргаж ирэхийг зорилоо..

[Түлхүүр үг]

Өв залгамжлал, өвлөгдөх хөрөнгө, өвлөгдөх хөрөнгийн үнэ цэнийг хуваах зарчим, өвлөгдөх хөрөнгийг гэрээгээр хуваарилах.

I. Оршил

Монгол Улс төдийгүй бусад улс, орнуудын эдийн засаг, нийгэм хөгжиж, тэлэхийн зэрэгцээ тухайн улсын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор дотоодын хууль тогтоомжийг нийгмийн амьдралд нийцүүлэн боловсронгуй болгон шинэчлэх, зохих өөрчлөлтийг хийдэг. Бид 1992 оны Үндсэн хуулиар өмчийн эрхийг тунхаглаж, түүнтэй холбогдох өв залгамжлал бодитоор хэрэгжих эрх зүйн зохицуулалтыг 2002 онд Иргэний хуульд тусган өгч, түүнээс хойш дорвитой өөрчлөлтгүйгээр өнөөдрийг хүржээ.

Иргэний хууль дахь өв залгамжлалын харилцаанд оролцож буй хууль ёсны өвлөгчид өвлөгдөх хөрөнгийн биет байдал болон ирээдүйд олох үр шим, үр ашигт төдийлөн ач холбогдол өгдөггүй бөгөөд энэ талаар тусгайлан зохицуулсан зохицуулалт, судалгаа байхгүй нь судлах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Түүнчлэн, Иргэний хуульд өвлөгдөх хөрөнгийг хуульд зааснаар болон гэрээслэлээр хуваарилах аргыг хуульчилж өгсөн бөгөөд хууль ёсны өвлөгчид өөр хоорондоо гэрээ байгуулах замаар өвлөгдөх хөрөнгийг хуваарилах аргыг ашиглах эрх нь нээлттэй байхаар зохицуулсан. Энэ талаарх харилцааг тусгайлан зохицуулаагүй орхигдуулсан нь өвлөгдөх хөрөнгийг гэрээгээр хуваарилахад өв хөрөнгийн үнэ цэнийг алдагдуулахгүйгээр хэрхэн хуваарилалт хийх асуудлыг судлах зайлшгүй шаардлага тулгарч байна.

II. Онолын хэсэг

A. Өвлөгдөх хөрөнгийн бүрэлдэхүүн, түүний иж бүрдлийн тухай

Иргэний эрх зүйн харилцаанд аливаа этгээд хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн болон эдийн бус баялгийг эзэмшилдээ олж авсан тохиолдолд эд хөрөнгө хэмээх ойлголт бий болдог. Харин өөрийн эзэмшилдээ баялгийг ийнхүү шударгаар олж авсан этгээд эд хөрөнгөө Иргэний хуулийн 515 дугаар зүйлийн 515.1 дэх хэсэгт заасны дагуу бусдад өвлүүлэх харилцаанд оруулснаар тухайн эд хөрөнгө нь өвлөгдөх хөрөнгө болно. Өв залгамжлуулж буй эд хөрөнгө, өвлүүлж буй бүх эд зүйлсийг өв хөрөнгө гэж нэрлэдэг.¹ Хувийн эрх зүйн тайлбар толь бичигт өвлөгдөх хөрөнгө (inheritance) гэдэг ойлголт нь хуулийн дагуу болон гэрээслэлээр өвлөгдөх хөрөнгийг болон түүний хэсгийг хамруулж ойлгодог. Энд өвлөгдөх хөрөнгө болон түүнтэй холбоотой

¹ Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй (Олон улсын хувийн эрх зүйн хүрээн дэх судалгаа) Уб., 2018. 68 дахь тал

бүх эрхтэй холбоотой өргөн утгыг хамарсан бүх тохиролцоо орно.² Өвлөгдөх хөрөнгө нь зөвхөн өв залгамжлалын харилцаанд л яригдах асуудал бөгөөд өөр бусад иргэний эрх зүйн харилцаанд яригдахгүй.

Монгол Улс дахь өвийн бүрэлдэхүүнд эд юмс, оюуны үнэт зүйл түүний дотор эд хөрөнгийн эрх ба үүрэг багтана.³ Бүрэн эрх залгамжлах зарчмын хүрээнд өвлүүлэгч дан ганц хөдлөх болон үл хөдлөх хөрөнгөө өвлүүлээд зогсохгүй, өвлөгдөх хөрөнгийн бусад бүрэлдэхүүн хэсэг болох эрх, үүрэг давхар өвлөгчдөд ижил хэмжээгээр шилждэг.⁴ Өвлөгдөх хөрөнгийн бүрэлдэхүүн болох хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө нь өвлөгдөөд зогсохгүй оюуны үнэт зүйл, эзэмшигчдээ эдийн засгийн давуу байдал бүрдүүлэх зорилготой эрх мөн адил дээрх харилцааны дагуу өвлөгддөг. Өвийн бүрэлдэхүүнийг шинжээр нь ангилсныг зураг 1-ээс харж болно.

гийн бүрэлдэхүүн.



(1) Үл хөдлөх хөрөнгө нь газар түүнээс салган хэрэглэж үл болох зүйл буюу газар, орон сууц гэх мэт үл хөдлөх хөрөнгө,

(2) Хөдлөх хөрөнгө нь үл хөдлөхөөс бусад эд хөрөнгө болох мал сүрэг, үнэт эдлэл гэх мэт хөдлөх хөрөнгө,

(3) Эд хөрөнгийн эрх нь оюуны үйл ажиллагааны үр дүн болох оюуны өмч, компани, нөхөрлөл, хоршоо, орон сууц хөлслөгчийн эрх гэх мэт эд хөрөнгийн эрх,

(4) Эд хөрөнгийн үүрэг нь баглан даалтын үүрэг, асран тэтгэх гэрээний үүрэг зэрэг болж байна.

Өвийн бүрэлдэхүүнд хамаарагдахгүй эрх ба үүргийг тусгайлан авч үзээгүй нь эрх зүйн хийдэл⁵ болж байгаа боловч энэ талаар

² С.Должин, Хувийн эрх зүйн тайлбар толь бичиг. Уб., 2019. 163 дахь тал

³ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 43 дахь тал

⁴ Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 11 дэх тэл

⁵ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 54 дэх тал

иргэний хуулийн зарим харилцаанд зохицуулалтыг хийж өгсөн. Тухайлбал, тэтгэлэг төлөх эрх, бусдын эрүүл мэндэд учруулсан гэм хорыг нөхөн төлүүлэх эрх, төлөөллийн үүрэг, үүргийн гүйцэтгэлийн үүрэг гэх мэт хүний хувийн байдлаас салшгүй холбоотой эрх, үүрэг өвлөгдөхгүй.

Өв хөрөнгийн бүрэлдэхүүнд өвлөх эрх нээгдэх өдөр өвлүүлэгчид хамаарч байсан эд зүйлс, өөр эд хөрөнгө, түүний дотор эдийн эрх болон үүргүүд багтдаг.⁶ Өвлөгдөх хөрөнгийн бүрэлдэхүүн болох хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө нь өвлөгдөөд зогсохгүй оюуны үнэт зүйл, эзэмшигчдээ эдийн засгийн давуу байдал бүрдүүлэх зорилготой эрх мөн адил дээрх харилцааны дагуу өвлөгддөг. Энэ талаар доктор Б.Улаанбаатар “...өвлөгч нь өвлүүлэгчийнхээ хууль зүйн бие хүний үргэлжлэл болохынхоо хувьд өвлүүлэгчийн эрх, үүргийг бүхэлд нь эрх зүйн харилцаанд байр суурийг нь эзлэх ёстой” гэжээ.⁷

Доктор Б.Улаанбаатар⁸, Т.Мөнхжаргал⁹ нарын бүтээлүүдэд бүрэн эрх залгамжлах зарчмын хүрээнд өвлүүлэгч дан ганц хөдлөх болон үл хөдлөх хөрөнгөө өвлүүлээд зогсохгүй, өвлөгдөх хөрөнгийн бусад бүрэлдэхүүн хэсэг болох эрх, үүрэг давхар өвлөгчдөд ижил хэмжээгээр шилждэг гэж тодорхойлсон.

Иргэний эрх зүйн зорилгуудын нэг бол эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх явдал бөгөөд энэхүү хамгаалалтыг Иргэний хуульд тогтоож өгсөн байдаг. Өвлөгдөх хөрөнгийн бүрэлдэхүүн болох эрх болон үүргийг товч тайлбарлавал, өвлүүлэгч бусдад үүрэг хүлээсэн байгаад нас барсан тохиолдолд бусад шаардах эрхтэй этгээд хохирох ёсгүй, харин энэ үүргийг өв хүлээн авсан хэмжээгээрээ биелүүлэхийг өв залгамжлагч нараас шаардах эрхтэй гэх байдлаар тодорхойлж болно. Үүнтэй холбоотойгоор хөрөнгийн иж бүрдлийн асуудал хөндөгдөнө. Хөрөнгийн иж бүрдэл гэдэг нь тухайн хөрөнгөтэй амин холбоотой, салгаж болохгүй цогц эрх, үүрэг юм. Доктор Б.Улаанбаатар өвийг өөрийн гэсэн онцгой чанар бүхий туялзуур агуулгатай гэж тодорхойлоод, хөрөнгийн иж бүрдлийг үйлдвэрийн жишээгээр тайлбарлахдаа, үйлдвэрийн иж бүрдэлд үйлдвэрийн газар, барилга, тоног төхөөрөмж, эд хогшил, түүхий эд, шаардах эрх, өр зэргийг багтаасантай адилтган үзэж болно гэжээ.¹⁰

⁶ Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй (Олон улсын хувийн эрх зүйн хүрээн дэх судалгаа). Уб., 2018. 68 дахь тал.

⁷ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 76 дахь тал.

⁸ Мөн тэнд. Бүрэн эрх залгамжлах зарчмыг тодорхойлсон.

⁹ Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Бүрэн эрх залгамжлах зарчмыг тодорхойлсон. 11 дэх тэл

¹⁰ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 38 дахь тал

Өнөөгийн даяарчлагдаж буй нийгэмд аливаа этгээдийн эд хөрөнгө үнэ цэнтэй бөгөөд үл хуваагдах байдлаараа гадаад болон дотоод хүчин зүйлсээс шалтгаалан тухайн хөрөнгийн эдийн засгийн үр ашиг, ирээдүйд олох үр шим нь чухал байдаг. Энэхүү үр ашиг, ирээдүйд олох үр шимийг нь үл хайхран хууль ёсны өв залгамжлагчдад бялуу хуваар зарчмаар тэнцүү хэмжээгээр хуваарилах эсхүл салган хуваах нь учир дутагдалтай билээ. Хэдийгээр иргэний хуульд өв хөрөнгийг өв залгамжлалд оролцсон бүх өвлөгчид хэлэлцэн зөвшөөрөлцөж, биет байдлаар өвлөх эрх нь нээлттэй боловч өвлөгдөх хөрөнгийн үнэ цэн, шинж чанар, иж бүрдлийг бүрэн байдлаар нь хуваарилахтай холбогдсон эрх зүйн зохицуулалт дутмаг байна. Энэ харилцааг зохицуулаагүй байгаа нь өвлүүлэгчийн хэвийн үйл ажиллагаатай явагдаж буй хөрөнгийг цаашид үргэлжлүүлэх, эс үргэлжлүүлэх амин чухал хэрэгцээг хэрхэх талаар орхигдуулсан байна. Доктор Б.Улаанбаатар¹¹, Т.Мөнхжаргал¹² нар өөрсдийн бүтээлдээ “Өвлүүлэгчийн хүсэл зоригийг тооцох зарчим”-ыг тодорхойлохдоо өвлүүлэгч өв хөрөнгөө өөрийн гэр бүл, ураг төрлийн хүмүүстээ үлдээх байсан болов уу гэсэн таамаглалаас эхлэлтэй гэж дүгнэсэн байдаг. Өвлүүлэгч мэдээж гэр бүл, ураг төрлийн хүмүүст өв хөрөнгөө өвлүүлэх нь өөрийн эцсийн хүсэл байж болно. Гэхдээ өвлүүлэгч үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг байгаад уг хөрөнгийг өөрийг нь нас барсны дараа устгах, мөнгөн хэлбэрээр бусдад хуваах гэсэн хүсэл зориг байхгүй байж болно. Өөрөөр хэлбэл, хэрэв өвлүүлэгч амьд байхдаа үл хөдлөх хөрөнгийн хэвийн үйл ажиллагааг шууд зогсоож, үр ашиггүй болгон үнэлгээнд суурилсан мөнгөн хэлбэрээр бусдад өгөхгүй байх байсан болов уу хэмээх түүний хүслийн эсрэг ажиллагаа хөндөгдөж болзошгүй байна.

Түүнчлэн, манай иргэний хуульд зөвхөн биет эд хөрөнгө бус оюуны өмч болон бусдаас шаардах эрх, түүнтэй холбогдох үүргийг давхар өвлүүлэгчээс өвлөгчид шилжих харилцааг тусгаж өгсөн. Үүнтэй адил эдийн бус хөрөнгө болох оюуны өмч, тусгай зөвшөөрөл, утга зохиол, шинжлэх ухаан, урлагийн бүтээлийн зохиогчийн эрх, ноухау зэрэг бүгд өвлүүлэгчийн өмчид хамаарч байх бөгөөд үүнийгээ өвлүүлэх эрхтэй. Ноу-Хау гэдэг нь чухал ач холбогдол бүхий техникийн шийдэл болон туршлага, мэдлэгт тулгуурласан үйлдвэрлэлийн нууц юм.¹³

Доктор Б.Улаанбаатар “Өвлүүлэгчийн эрх ба үүрэг нь өвлөгчид шилжихдээ цул нэгдмэл байдалтай ба өөрчлөгдөшгүй байдаг

¹¹ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 81 дэх тал

¹² Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 13 дахь тал

¹³ С.Должин, Хувийн эрх зүйн тайлбар толь бичиг. Уб., 2019. 148 дахь тал

онцлогтой. Ингэхдээ өвлүүлэгчийн эд хөрөнгийн бус харин бүх эрх ба үүрэг өвлөгчид шилжинэ”¹⁴, доктор Т.Мөнхжаргал “...өв залгамжлагч нь өвлүүлэгчийн өвлөгдөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрх, үүргийг бүхэлд нь авах бөгөөд өвлүүлэгч бусад этгээдэд үүрэг хүлээсэн бол тийнхүү өвлөж авсан эд хөрөнгийн хэмжээгээр бусдын өмнө хүлээсэн үүргийг хариуцна”¹⁵ гэж тус тус тодорхойлжээ. Иймд өв тодорхойлох, өвлөгдөх хөрөнгийг хуваарилахдаа түүний иж бүрдлийг харгалзан үзэх шаардлага тулгарч байна. Нөгөө талаас нэг бүрийн шинжээр тодорхойлогдох эд хөрөнгө өвлүүлэгчийн өв хөрөнгөнд яригдаж болно. Тухайлбал, хуваагдаж болохгүй, хамтран өмчлөх боломжгүй эд хөрөнгө болох гар утасны дугаар, гар утас, автомашин зэрэг зөвхөн нэг хүний өмчлөл дээр байдаг хуваагдаж болохгүй өв хөрөнгийн эрхийг хуваарилах арга нь одоогийн иргэний хуульд талууд тохиролцох эсвэл худалдан борлуулж мөнгөн хэлбэрээр хуваах л боломж байна.

Б. Өвлөгдөх хөрөнгийг хуваарилах талаарх онол, үзэл баримтлал

(1) Иргэний эрх зүй ба Өв залгамжлалын эрх зүй

Иргэний эрх зүйн харилцааны нэг оролцогч болох хүн нь иргэний эрх зүйн харилцаанд оролцоходоо тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээн дангаараа болон бусадтай хамтран эд хөрөнгийг өөрийн өмч болгон эзэн суун өөрийн өмчийг захиран зарцуулдаг. Энэхүү эд хөрөнгийн өмчлөгч нь нас барснаар түүний өмчлөлд байсан эдийн харилцаа нь шууд дуусгавар болох учиргүй бөгөөд үүнд хүрч үйлчлэх харилцааг Өв залгамжлалын эрх зүй зохицуулдаг учиртай билээ.

Аливаа шинжлэх ухаан, салбар шинжлэх ухаан нь өөрийн судлагдахуунаа судлахын тулд зохицуулах зүйл, зохицуулалтын аргатай байдаг. Тэгвэл өв залгамжлалын эрх зүй нь нас барсан бие хүн буюу өвлүүлэгчээс бусад этгээд болох өвлөгчдөд өв хөрөнгө болон эдийн эрх, үүргээ шилжүүлэх бүрэн цогц харилцааг зохицуулдаг байна. Эрх залгамжлал, өв, түүний бүрэлдэхүүн, өвийн эрх залгамжлал, түүний учир холбогдол, өв залгамжлах үндэслэл, өв нээгдэх, түүний хугацаа болон газар, өв залгамжлалын субъект, өв залгамжлалын зарчим зэрэг нь өв залгамжлалын эрх зүйн тулгуур ухагдахуун бөгөөд өв залгамжлалын эрх зүй нь иргэний эрх зүйн бие даасан томоохон институт болохыг харуулдаг.¹⁶ Өв залгамжлал, түүний эрх зүйн зохицуулалтын зорилго, үр дүн буюу эцсийн бодит илрэл нь иргэн, хуулийн этгээд, төрд эд хөрөнгө бий болж өмчлөх эрх шинээр үүсэж

¹⁴ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 21 дэх тал

¹⁵ Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 11 дэх тал

¹⁶ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 12 дахь тал

байдагт оршино.¹⁷ Иймээс аливаа этгээд эд хөрөнгө өвлүүлэх болон өвлөн авснаар иргэний эрх зүйн харилцаа тэр дундаа өв залгамжлалын эрх зүйн харилцаа үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох үндэслэл нь болж байна. Өв залгамжлалын эрх зүй нь Иргэний эрх зүй тэр дундаа өмчийн эрх зүй, гэр бүлийн эрх зүй, мөн бусад салбар эрх зүй болох эрүүгийн эрх зүйн зааг дээр орших өөрийн мөн чанараа хадгалж буй өөрийн гэсэн судлагдахуунтай эрх зүй юм. Иргэний эрх зүйн зарчим нь иргэний эрх зүйн хэм хэмжээг тогтоох, иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, эрх үүргийг хэрэгжүүлэхэд мөрдлөг болгох үзэл баримтлал буюу үндсэн чиглэмж юм.¹⁸ Эрх зүйн зарчмыг хууль тогтоогчид, шүүгчид, эрдэмтэд эрх зүйг буй болгох, түүнийг танин мэдэх, зөв хэрэглэх зорилгын үүднээс буй болгодог.¹⁹ Өв залгамжлалын харилцаанд иргэний эрх зүйн суурь зарчим болон өв залгамжлалын эрх зүйн хэд хэдэн зарчмыг баримтална.

(а) Иргэний эрх зүйн зарчмын тухайд

Тэгш байдлын зарчим

Энэхүү зарчим нь иргэний эрх зүйн зохицуулах зүйл, зохицуулалтын аргыг тодорхойлох гол зарчим болдог. Уг зарчимтай иргэний эрх зүйн бусад зарчмуудыг холбон тайлбарлахаас гадна бусад зарчмууд ч энэхүү зарчмыг хэрэгжихэд туслах гол хөшүүрэг болдог.²⁰ Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын аль нэг нь нөгөөгөөсөө давуу эрхтэй байж болохгүй бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдийн аль нь ч бие биеэсээ давуу болон сул, илүү эсхүл дутуу эрхтэй байх ёсгүй.²¹ Иргэн, эсхүл хуулийн этгээд, эсхүл төрийн байгууллагын аль нь байхаас үл хамааран иргэний эрх зүйн харилцаанд оролцож байгаа бол эдгээр этгээд нь бүгд тэгш эрхтэй байна.²² Энэ зарчим нь өв хүлээн авагчтай шууд холбогдож хэрэгжих юм. Тухайлбал, өвлөгчдийн хэн аль нь өв хүлээн авахаас татгалзсан, гэрээсэлснээс бусад тохиолдолд өв хөрөнгийг тэгш байдлын зарчмын үндсэн дээр ижил хэмжээтэй хүлээн авах ба тухайн өвлүүлэгч бусад этгээдэд тодорхой үүрэг хүлээсэн бол мөн адил үүргийг өвлөгчид ижил тэнцүү хэмжээгээр хүлээн авах байдлаар хэрэгжих юм.

Бие даасан байдлын зарчим

Иргэний эрх зүйн харилцаанд аливаа этгээдийг оролцохыг

¹⁷ Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 7 дахь тал

¹⁸ Хууль зүйн яам, Иргэний эрх зүйн гарын авлага. Уб., 2013. 16 дахь тал

¹⁹ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017 75 дахь тал

²⁰ Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүй I Ерөнхий анги. Уб., 2020. 33 дахь тал

²¹ Мөн тэнд.

²² Э.Байгаль, Иргэний эрх зүйн ерөнхий анги. Уб., 2009. 7 дахь тал

төрөөс буюу бусад субъектээс албадах боломжгүй.²³ Уг зарчим нь гэрээний эрх чөлөөний болон хувийн хэрэгт хөндлөнгөөс үл оролцох зарчимтай нягт холбогддог. Энэ зарчмын хүрээнд оролцогч нь биеэ даасан эрх зүйн этгээд учраас өөрийн хүсэл зоригт үндэслэн иргэний эрх зүйн харилцаанд оролцоно. Энэ зарчим иргэний эрх, үүргийг ямар нэг хөндлөнгийн хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх агуулгыг давхар илэрхийлдэг.²⁴ Өвлүүлэгч гэрээслэлийн журмаар өв хөрөнгөө өвлүүлэхдээ хэн нэгний хараат бус, зөвхөн өөрийн эцсийн хүсэл зоригоо энэхүү зарчмын хүрээнд хэрэгжүүлж буй хууль зүйн факт гэж тодорхойлж болох юм.

Өмчийн халдашгүй байдлын зарчим

Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, 3 дахь хэсэгт “өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно”, арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй” гэж заасан нь өмчлөх эрх зүйн зохицуулалттай холбоотой Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан суурь зарчим гэж тодорхойлж болно. Мөн Монгол Улсын Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт “өмчлөгч хөрөнгөө өөрийн үзэмжээр, чөлөөтэй эзэмших, захиран зарцуулах эрхтэй” гэж заасан байдаг. Энэ хүрээнд төрөөс өвлүүлэгчийг нас барснаас хойш өөрийн хүсэл зоригийн илэрхийлэл болох гэрээслэл, эсхүл хуульд зааснаар өвлүүлэхдээ өв хөрөнгийг өвлүүлэгчид хүлээлгэн өгөх хүртэл хамгаалалт тогтоож буй явдал нь энэ зарчимд хамааралтай байна.

Гэрээний эрх чөлөөний зарчим

Иргэний эрх зүйн харилцаа, тэр дундаа гэрээний эрх зүйн гол зарчим бол гэрээний эрх чөлөөг хангах зарчим юм. Энэ нь хувийн харилцаагаа бие даан зохицуулах үндсэн эрхээс үүдэлтэй бөгөөд аливаа этгээд иргэний эрх зүйн гэрээ байгуулах эсэх, байгуулж байгаа бол ямар агуулгаар байгуулахаа өөрөө тодорхойлох, гэрээний нөгөө талтайгаа тохиролцон тодорхойлох эрхтэй байна.²⁵ Энэхүү зарчмын хүрээнд оролцогч нь гэрээний төрөл, агуулга, гэрээ байгуулах эсэхээ хэнээс ч түүний дотор төрийн байгууллага албан тушаалтнаас хараат бусаар сонгох эрхтэй байна. Өөрөөр хэлбэл, иргэний эрх зүйн харилцааны оролцогч нь хууль тогтоомжоор хориглоогүй агуулгаар гэрээ байгуулах эрх чөлөөтэй.²⁶ Гэхдээ энд гэрээслэлийг гэрээ эсхүл

²³ Мөн тэнд, 8 дахь тал

²⁴ Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүй I Ерөнхий анги. Уб., 2020. 34 дэх тал

²⁵ Э.Байгаль, Иргэний эрх зүйн ерөнхий анги. Уб., 2009. 9 дэх тал

²⁶ Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүй I Ерөнхий анги. Уб., 2020. 35 дахь тал

хэлцэлд тооцох эсэхэд хариулт өгөх учиртай. Гэрээ, хэлцлийг ялган зааглахын тулд түүний агуулга, үндсэн шинжийг нь тодорхойлох нь чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Иргэний хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл /эс үйлдэхүй/-г хэлцэл гэнэ.”, 2 дахь хэсэгт “Нэг этгээд хүсэл зоригоо илэрхийлэн хэлцэл хийж болно.” гэжээ. Гэрээ гэдэг нь иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэгдсэн, хоёр ба түүнээс дээш этгээдийн хооронд хийсэн тохиролцоо гэж тодорхойлсон байна.²⁷

Доктор Ц.Оюунаа гэрээслэлийг “Өөрийн үзэл баримтлалын ач холбогдлоороо гэрээслэлийн эрх чөлөө бол гэрээний эрх чөлөөний дурын хэлбэрийн нэг юм. Энэ нь өөрийн зорилгоороо, агуулгаараа, хүсэл зоригийн нэг талын чанараараа гэрээний эрх чөлөөнөөс үндсээрээ ялгаатай байдаг”²⁸, доктор Т.Мөнхжаргал “гэрээслэл нь гэрээслэгчийн санаа зоригийг илэрхийлсэн эрх зүйн үр дагавар бүхий үйлдэл факт бөгөөд энэ утгаар нь Иргэний эрх зүйн нэг талын хэлцэл хэмээн ойлгож системчилж ирсэн юм. Өөрөөр хэлбэл иргэн эд хөрөнгөө захиран зарцуулж буй үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын хэлбэр бөгөөд өвлүүлэгч нас барсныхаа дараа эд хөрөнгөө бүгдийг буюу зарим хэсгийг нэг ба хэд хэдэн этгээдэд шилжүүлэхээр хуульд заасан нөхцөл журмын дагуу хийсэн нэг талын хэлцэл болно”²⁹ гэж тус тус тайлбарласан. Гэрээслэлд зөвхөн өвлүүлэгчийн хүсэл зориг давамгайлдаг бөгөөд өвлөгчийн хүсэл зориг төдийлөн ач холбогдолгүй бол гэрээнд талуудын хүсэл зоригийн илэрхийлэл ихээхэн чухал ач холбогдолтой. Гэрээний талууд эрх зүйн чадамжтай байхыг шаарддаг бол хэлцлийн нэг тал болох өвлүүлэгч нь л эрх зүйн чадамжтай байхыг шаарддаг. Энэ утгаараа гэрээслэл нь хэлцэлд хамрагдана.

(б) Өв залгамжлалын эрх зүйн зарчмын тухайд

Өв залгамжлалын эрх зүй нь Иргэний эрх зүйн зарчмыг удирдлага болгохын зэрэгцээ өөртөө баримтлах тусгай зарчмуудтай байна.³⁰ Өв залгамжлалын эрх зүй нь иргэний эрх зүйн харьцангуй бие даасан институт болохын хувьд иргэний эрх зүйн нийтлэг зарчмын зэрэгцээ энэхүү институтийн өвөрмөц онцлог байдлыг тусган илэрхийлсэн тусгай зарчмыг буй болгожээ.³¹ Доктор Т.Мөнхжаргал

²⁷ Хууль зүйн яам, Иргэний эрх зүйн гарын авлага Уб., 2013. 31 дэх тал

²⁸ Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй (Олон улсын хувийн эрх зүйн хүрэн дэх судалгаа) Уб., 2018. 98 дахь тал

²⁹ Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 47 дахь тал

³⁰ Мөн гэнд. 11 дэх тал

³¹ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 75

өв залгамжлалын эрх зүйд бүрэн эрх залгамжлах зарчим, гэрээслэл чөлөөтэй байх зарчим, өв залгамжлагчдын эрх ашгийг хамгаалах зарчим, өвлүүлэгчийн хүсэл зоригийг тооцох зарчим, уламжлалт зан заншлын хэм хэмжээг хүндэтгэх зарчим, өв хүлээн авагчдын чөлөөт сонголтын зарчим гэх 6 зарчмыг тодорхойлсон³² бол доктор Б.Улаанбаатар нь Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт бүтээлдээ ёс суртахуун ба хууль түүнчлэн өвлүүлэгч, өвлөгчид өв залгамжлахтай холбогдсон этгээд, хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалах зарчмыг тус тус тодорхойлсон байдаг.³³

Бүрэн эрх залгамжлах зарчим

Энэхүү зарчмыг доктор Б.Улаанбаатар өвлүүлэгч өв хөрөнгөө өвлөгчид өвлүүлэхэд хуульд зааснаас бусад тохиолдолд ямар нэг завсрын дамжлага байх ёсгүй бөгөөд өвлөгч нь өвлүүлэгчийнхээ хууль зүйн бие хүний үргэлжлэл болохынхоо хувьд өвлүүлэгчийн эрх, үүргийг бүхэлд нь эрх зүйн харилцаанд байр суурийг нь эзлэх ёстой³⁴, доктор Т.Мөнхжаргал өв залгамжлагч нь өвлүүлэгчийн өвлөгдөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрх, үүргийг бүхэлд нь авах бөгөөд өвлүүлэгч бусад этгээдэд үүрэг хүлээсэн бол тийнхүү өвлөж авсан эд хөрөнгийн хэмжээгээр бусдын өмнө хүлээсэн үүргийг хариуцна гэж тус тус тодорхойлжээ.³⁵ Өв залгамжлуулах эд хөрөнгийн бүрэлдэхүүнд эд зүйлс нэгдүгээрт тавигддаг, учир нь тэдгээр нь иргэн бүрийн эд хөрөнгийн үндэс нь болж байдаг.³⁶

Гэрээслэл чөлөөтэй байх зарчим

Доктор Б.Улаанбаатар “Өвлүүлэгч нас барсан тохиолдолд өөрийнхөө үзэмжээр өөрийнхөө өвийг захиран зарцуулах буюу түүнийг захиран зарцуулахгүй байх явдлыг илэрхийлнэ, гэрээслэл чөлөөтэй байх зарчим нь гэрээслэлийг үйлдэхэд өвлүүлэгчийн хүсэл зориг бүрэн хэмжээгээр тусгалаа олсон байх, тэрээр дараа нь гэрээслэлээ цуцлах буюу өөрчлөх нь чөлөөтэй байх бөгөөд хэн ч өвлүүлэгчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан шууд буюу шууд бус байдлаар өөрт ашигтай гэрээслэл бичүүлэхээр түүнийг “шахах”, дарамтлах, өөрт нь буюу ойр дотны нь хүмүүст гэм хор учруулахаар айлган сүрдүүлэх ёсгүй болохыг харуулна”³⁷, доктор

дахь тал

³² Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 11-15 дахь тал

³³ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017 83 дахь тал

³⁴ Мөн тэнд. 76 дахь тал

³⁵ Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 11 дэх тал

³⁶ Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй (Олон улсын хувийн эрх зүйн хүрээн дэх судалгаа) Уб., 2018. 69 дэх тал

³⁷ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 77 дахь тал

Ц.Оюунаа “Гэрээслэлээр өвлөхийн язгуур эхлэл нь гэрээслэлийн эрх чөлөө, гэр бүлийн эрх ашгийг хамгаалах гэдэг хоёр үндсэн суурь зарчмуудын хослол юм. Хэрэг дээрээ хаана ч тэр гэрээслэлийг нэг талын хэлцэл, өвлүүлэгчийн хүсэл зоригийн үйлдэл хэмээн ойлгодог байна”³⁸, доктор Т.Мөнхжаргал “Гэрээслэгч гадны ямар нэг нөлөөлөлгүйгээр эд хөрөнгөө өөрийн үзэмжээр хэнд ч гэрээслэх, гэрээслэлээ өөрчлөх, цуцлах, гэрээсэлсэн эд хөрөнгийн зориулалтыг заах, эдгээр нөхцөлийг гэрээслэл биелүүлэгч болон бусад этгээд заавал хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг нь императив шинжийг агуулна, Гэрээслэгч гадны ямар нэг шахалт хавчилт, хууран мэхлэлт, амьдрал ахуйн гарцаагүй хүнд нөхцөл зэрэг нөлөөлөлгүй зөвхөн өөрийн дотоод зориг хүслийн дагуу үзэмжээрээ эд хөрөнгөө хэнд ч гэрээслэх, нэгэнт хийсэн гэрээслэлээ өөрчлөх, цуцлах эрхтэй”³⁹ гэж тус тус гэрээслэлийн агуулга, шинжийг тодорхойлсон.

Зайлшгүй өвлөгчдийн эрх ба ашиг сонирхлыг хангах зарчим

Өвлүүлэгч шууд буюу шууд бусаар зайлшгүй өвлөгчид заавал ногдох өвийн хууль ёсны хувийг гэрээслэлээр хасаж болохгүй байдлыг илэрхийлнэ.⁴⁰ Өмчлөгч эд хөрөнгөө бүрэн мэдэж захиран зарцуулж буйн нэг хэлбэр нь өвлүүлэгч эд хөрөнгөө бүгдийг буюу зарим хэсгийг ямар ч субъектэд гэрээсэлж байгаагаар илэрч байна. Харин өв залгамжлагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс хуульд заасан зарим тохиолдолд уг эрхийг хязгаарлаж болдог.⁴¹ Энэхүү хамгаалалтыг 2002 онд хууль тогтоогч Иргэний хуулийн 522 дугаар зүйлийн 522.3 дахь хэсэгт хуульчилж өгсөн байдаг бөгөөд энэхүү зарчмын агуулга нь нэг талаар өвлүүлэгчийн эрхийг хязгаарлаж, нөгөө талаар хууль ёсоор өвлөгчдийн эрх ашгийг хамгаалж буй нэг илрэл юм. Өв залгамжлуулагчийг нас барснаар амь зуулгын хэрэгслээ үлэмж хэмжээгээр алдаж, эд материалын хүнд байдалд орж, амьдрахад хэцүү болсон тэр хүмүүсийг хамгаалах нийгмийн хамгааллын нэг хэлбэр юм.⁴² Өв залгамжлалын харилцааны суурь үндэснүүдийн нэг болох гэр бүлийн харилцааны оролцогчид бие биеэ тэжээн тэтгэх үүрэг хүлээсэн байдагт оршдог. Өвлүүлэгч хэдийгээр өөрийн шууд хүсэл зоригийн үндсэн дээр хууль ёсны бус өвлөгчид гэрээслэлийн журмаар өв хөрөнгөө өвлүүлэх боловч гэр бүлийн харилцаа дахь тэжээн тэтгэх үүрэг давхар энд хүрч үйлчилж өвлөгчдийн эрх ашгийг

³⁸ Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй (Олон улсын хувийн эрх зүйн хүрээн дэх судалгаа) Уб., 2018. 203 дахь тал

³⁹ Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 11 дэх тал

⁴⁰ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 78 дахь тал

⁴¹ Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 12 дахь тал

⁴² Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй (Олон улсын хувийн эрх зүйн хүрээн дэх судалгаа) Уб., 2018. 79 дэх тал

тодорхой хамгаалж буй явдал юм.

Өвлүүлэгчийн хүсэл зоригийг тооцох зарчим

Өв залгамжлалын эрх зүйд хуулиар өвлөгчдийн хүрээг хэрэв өвлүүлэгч өвөө өөрөө захиран зарцуулсан тохиолдолд хэнд үлдээх байсан, чухам хэнийг хууль ёсны өвлөгчид хамааруулах байсан гэсэн төсөөлөлд тулгуурласан байдаг.⁴³ Энэ нь хууль ёсоор өв залгамжлагчдын хүрээ, тэдгээрийн өв хүлээн авах эрэмбэ дарааллыг тодорхойлж, тогтоохтой холбогдож үүсдэг.⁴⁴ Хүсэл зоригийг тооцох зарчим нь өвлүүлэгч эд хөрөнгөө үр хүүхэд, ураг төрөлдөө өвлүүлэн үлдэх хүсэл, зориг нөгөө талаас хууль ёсны өв залгамжлагчид уг өвийн зохих хувийг хуульд зааснаар авах эрхтэй гэсэн хоёр талын санаа зоригийн бодит хэрэгжилтээр илэрч байдаг.⁴⁵ Энэхүү зарчмын суурь үндэс нь өвлүүлэгчийн хүсэл зориг гэр бүлийн гэр дундаа хамгийн ойрын гишүүддээ өвлүүлэх байсан эсэхийг харгалзаж, улмаар байхгүй тохиолдолд 2,3 дугаар ээлжийн өвлөгч⁴⁶-д өв шилжүүлэх таамгийг хийсвэрлэсэн агуулгаар илэрч байдаг. Энэ зарчим нь иргэний эрх зүйн бие даасан байдлын зарчмыг суурь болгодог ба өвлүүлэгчийн хүсэл зориг байгаа тохиолдолд түүнийг гэрээслэлээр хэрэгжүүлэх, гэрээслэл байхгүй эсхүл хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон тохиолдолд хууль ёсны өв залгамжлагчдад өв шилжих илрэлээр баталгаажна. Монгол Улсын Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.1, 520.2 дахь хэсэгт нэг, хоёр, гуравдугаар ээлжийн хууль ёсны өвлөгчдийн эрэмбийг зааж өгсөн ба энэ нь гэр бүлд суурилсан ураг төрлийн холбоог бататган өгсөн явдал юм.

Уламжлалт зан заншлын хэм хэмжээг хүндэтгэх зарчим

Монгол үндэстэн өндөр дээд элэнц, хуланцаас үе улиран дамжиж ирсэн өв залгамжлалын хэвшиж тогтсон уламжлалтай бөгөөд өнөөдөр ч бидний амьдрал ахуйд хэрэглэгдсээр байна. Өөрөөр хэлбэл өв залгамжлалын харилцааг эрх зүйн хэм хэмжээ болон зан заншлын хэм хэмжээгээр давхар зохицуулсаар иржээ.⁴⁷ Доктор Б.Улаанбаатар энэхүү зарчмыг өвийг хэн нэгний хууль бус буюу ёс суртахуунгүй халдлагаас хамгаалах зарчим гэж нэрлэн, шүүх монголчуудын хуульчлагдаагүй, уламжлалт зан заншлыг баримтлан төрсөн ах дүүсийн хооронд өвийн ногдох хувийн их багыг булаацалдсан хэрэг маргаанд зохих ёсоор харгалзан үзэх нь эрх зүйн хэм хэмжээг

⁴³ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 81 дэх тал

⁴⁴ Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 13 дахь тал

⁴⁵ Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 13 дахь тал

⁴⁶ Монгол Улсын Иргэний хуулийн 520 дугаар зүйл.

⁴⁷ Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 14 дэх тал

зөрчсөнд тооцох учиргүй гэж тодорхойлсон.⁴⁸

Өв хүлээн авагчдын чөлөөт сонголтын зарчим

Өвлөгчид нь өвийг хүлээн авч болно, мөн өвийг хүлээн авахаас татгалзаж болно. Хэрэв өвлөгчид өв хүлээн авахаа шууд буюу шууд бусаар илэрхийлээгүй бол тэднийг өв хүлээн авахаас татгалзсан хэмээн үзнэ.⁴⁹ Өв залгамжлалын эрх зүйд өвлүүлэгч хэнд, ямар нэр төрлийн эд хөрөнгөө гэрээслэх нь чөлөөтэй байхаас гадна, өв хүлээн авагч хэний ч шахалт, хавчилт нөлөөлөлгүйгээр өвийг хүлээн авах, эсэх талаар сонголт хийх эрхтэй.⁵⁰ Мөн энд иргэний эрх зүйн бие даасан зарчмын суурь харилцаа явагдаж байна. Онол болон судлаачдын дүгнэлтээр иргэний эрх зүйн харилцааны оролцогч нь харьцангуй бие даасан, хараат бусаар өөрийн иргэний эрх, үүргээ хэрэгжүүлэх учиртай ба үүнд нь бусад этгээд нөлөөлж болохгүй гэсэн үзэл санаа суурилагдсан байна. Энэ зарчмын хүрээнд өв хүлээн авагч ямар ч шалтгаан, тухайлбал, нийгэм, эдийн засаг, улс төр, хууль эрх зүй болон хувь хүний зүгээс ямар нэгэн хүчин зүйлтэй холбогдон өв хүлээн авах, татгалзах нь өв хүлээн авагчийн эрхэд хамаарч буй юм.

Ёс суртахуун ба хууль түүнчлэн өвлүүлэгч, өвлөгчид, өв залгамжлахтай холбогдсон хувь этгээд, хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалах зарчим

Энэ зарчмын үндэс нь өвлөгч ёс суртахуунтай байхыг шаардах ба энэ нь өв хүлээн авах нэг урьдчилсан нөхцөл болдог. Ёс суртахуун бол хүмүүст үүсмэл бус харин эсрэгээр уураг тархинд нь төрмөл орших хүний сайн сайхан зан чанарын цогц мөн.⁵¹ Ёс суртахуун гэдгийг нийгмийн зан заншилд нийцсэн, хуульд зөрчөөгүй гэж томъёолж болно. Тэгвэл ёс суртахуунгүй өвлөгч нь өвлүүлэгчийн хүсэл зоригийн эсрэг хийсэн үйлдэл, эс үйлдэхүй үйлдсэн тохиолдолд энэ нь гагцхүү хуулийн хүчин төгөлдөр шийдвэрээр баталгаажсан үед л өвлөх эрхээ алдах юм. Учир нь ёс суртахууныг зөрчихдөө бие хүн мэдэх төдийгүй хүсэж үйлдсэн байдаг, энэ утгаараа эрүүгийн эрх зүйтэй холбогдсон байдаг учраас үүнийг гэмт хэрэг гэж үзэн хууль тогтоогч Монгол Улсын Иргэний хуулийн 517 дугаар зүйлийн 517.1 дэх хэсэгт “Өвлүүлэгчийг, эсхүл хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөгчийг санаатайгаа алсан, түүнчлэн тэдгээрийн аль нэгний нас барах шалтгаан болсон бусад гэмт хэргийг санаатайгаар үйлдсэн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол уг гэм буруутай этгээд хуульд зааснаар болон гэрээслэлээр өвлөх эрхээ алдана” гэж тусгаж өгчээ.

⁴⁸ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 89 дэх тал

⁴⁹ Мөн тэнд. 83 дахь тал

⁵⁰ Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 14-15 дахь тал

⁵¹ Мөн тэнд. 84 дэх тал

В. Өвлөгдөх хөрөнгийг хуваарилах онол, үзэл баримтлал

Өвлөгдөх хөрөнгийг хуваарилах гэдэг нь өвлүүлэгчээс өвлөгдөх эд хөрөнгийг өв хүлээн авагчдад хуваарилан өгч буй хууль зүйн арга юм. Доктор Т.Мөнхжаргал өөрийн бүтээлдээ өвлөгдсөн эд хөрөнгийг хуваарилах хоёр арга замыг тодорхойлсон. Үүнд, өв залгамжлалд оролцсон бүх өвлөгчид ямар нэгэн маргаангүйгээр өөр хоорондоо тохиролцож, хууль ёсны ба гэрээслэлээр өвлөгч бүрд оногдвол зохих хэмжээгээр хуваарилах, өвлөгчид эд хөрөнгийг хэмжээ, нэр, төрөл болон бусад шалтгаан зааж маргавал шүүхийн шийдвэрээр тус тус хуваарилна гэжээ.⁵²

Хуульд зааснаар болон гэрээслэлээр өв залгамжлахад өвлөгдөх хөрөнгийг хуваарилах аргыг иргэний хуульд тодорхойлсон боловч иргэний эрх зүйн болон өв залгамжлалын эрх зүйн зарчимд тулгуурлан, иргэний хууль дахь өвийн харилцааг зохицуулсан бусад зохицуулалтуудаас өвлөгчид өвлөгдөх хөрөнгийг өөр хоорондоо хэлэлцэн, тохиролцох замаар хуваарилах, шүүхийн журмаар хуваарилах, эвлэрүүлэн зуучлах замаар хуваарилах, өв залгамжлалын гэрээ, өвлөгдөх хөрөнгийг хуваах гэрээгээр хуваарилах гэсэн аргуудыг хэрэглэх эрх нээлттэй байна.

Өв залгамжлах эрх хэрэгжих нөхцөлийг хоёр хуваан авч үзэж болно. Нэгт, бие хүн нас барснаас үүдэлтэй, хоёрт, нас барахаас өмнөх үед холбоотой харилцаан дээр үүсэж болно. Дээр дурдсанчлан эд хөрөнгийн өмчлөгч нь нас барснаар түүний өмчлөлд байсан эд хөрөнгийн харилцаа дуусгавар болж, хуульд зааснаар өвлөгчдөд өв хүлээн авах эрх нээгддэг бол тухайн өмчлөгч нас барахаас өмнө гэрээслэлээр өвлүүлэх эрхээ хэрэгжүүлж болох юм. Эндээс өвлүүлэгчийн эд хөрөнгийг хуульд заасан үндэслэлээр өвлөх, гэрээслэлийн журмаар өвлөх гэсэн сонголттой. Гэрээслэлээр өв залгамжлах нь өвлүүлэгчийн хүсэл сонирхлыг илүүд үздэг бол хууль ёсоор өв залгамжлах нь хуулийн дагуу түүний хөрөнгийг өвлөх ёстой өвлөгчийн хүсэл сонирхлын асуудал яригддаг.⁵³

Хуульд зааснаар өвлөгдөх хөрөнгийг хуваарилах

Хуульд зааснаар өвлөх нь өвлүүлэгч нас барсан байх, өвлүүлэгч хөрөнгөтэй байх, түүний дагалдах эрхтэй байх, хөрөнгөө захиран зарцуулах талаар зохих ёсоор хүсэл зоригоо илэрхийлээгүй байх, хууль ёсны өвлөгчтэй байх гэсэн шинжүүдийг агуулж байгаа төдийгүй өвлүүлэгч нас барсан байх нь хуульд зааснаар өвлөх харилцааны урьдчилсан нөхцөл болдог.

⁵² Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 78-79 дэх тал

⁵³ В.Оюумаа, «Өв залгамжлалын эрх зүйн харилцаанд нотариатчийн гүйцэтгэх үүрэг,» “Өв залгамжлалын олон улсын эрх зүйн зохицуулалт” сэдэвт эрдэм шинжилгээ судалгааны семинар 2007.

Хуульд зааснаар өвлөх, гэрээслэлээр өв залгамжлахын өвлөхийн гол ялгаа нь өвлүүлэгч өөрийн өвлөгдөх эд хөрөнгөө хуулийн шаардлага хангасан гэрээслэл үйлдсэн эсэхээс хамаарч байна. Хэрэв гэрээслэл үйлдээгүй бол доктор Ц.Оюунаагийн “хуульд зааснаар өв залгамжлах нь гэрээслэл байхгүй нөхцөлд гэрээслэлийн эсрэг өвлөх эрх шилжих журам юм”⁵⁴ гэх тодорхойлолттой нийцэх юм. Иймд хуульд зааснаар өвлөх нь өв залгамжлалын эрх зүйд өвлөгдөх хөрөнгийг хуваах ерөнхий үйлчлэх суурь журам бөгөөд өвлүүлэгч гэрээслэл үйлдээгүй байх, гэрээслэл хүчин төгөлдөр бус байх, өвлүүлэгч өвлөгчтэй болон өвлөгч нар өөр хоорондоо хэлэлцэн тохиролцоогүй нь энэхүү журам үйлчлэх урьдчилсан нөхцөл болно.

Гэрээслэлээр өвлөгдөх хөрөнгийг хуваарилах

Доктор Б.Улаанбаатар иргэний хуулийн 522 дугаар зүйлийн 522.2 дахь хэсэгт заасан гэрээслэгч төр буюу хуулийн этгээдэд хөрөнгө, түүний зориулалтыг зааж өгч буй явдал нь гэрээслэл чөлөөтэй байх зарчимтай зөрчилдсөн гэж шүүмжлэн уг заалтыг “Гэрээслэгч зориулалтыг нь зааж, өвийн эд хөрөнгөө гэрээслэж болно” гэж өөрчлөн найруулах санал⁵⁵ дэвшүүлсэн байдаг. Өөрөөр хэлбэл гэрээслэл нь гэрээслэл эрх чөлөөтэй байх зарчмын дагуу хийгдэх, зайлшгүй өвлөгчдийн эрх ба ашиг сонирхлыг хангах зарчмаар хязгаарлагдсан хууль зүйн үйлдэл байна. Доктор Б.Улаанбаатар өөрийн бүтээлдээ хэсэг судлаач нарын гэрээслэлийн тодорхойлолтууд зарим талаараа учир дутагдалтай хийгээд эд хөрөнгийн эрх болон, гэрээслэлийн амин сүнс болох иргэн нас барсан байх талыг орхигдуулсан гэж шүүмжилсэн⁵⁶ бол доктор Т.Мөнхжаргал өв залгамжлал хэмээх ойлголтыг иргэн нас барахтай холбоотой бөгөөд хэрэв нас бараагүй бол өв өвлөх тухай асуудал, тодруулж хэлбэл амьд сэрүүн байгаа хүний өвийг залгамжилна гэсэн ухагдахуун байж болохгүй⁵⁷ гэжээ. Үүнээс үзэхэд өв залгамжлалын эрх хэрэгжих гол нөхцөл нь өвлүүлэгч нас барснаар өв залгамжлах үйл явц хэрэгжиж эхлэх учиртай болж байна.

Өв залгамжлах гэрээгээр өвлөгдөх хөрөнгийг хуваарилах

Өв залгамжлах гэрээнд нэг талаас өвлүүлэгч нөгөө талаас өв залгамжлагч эсхүл хууль ёсны өвлөгчдийн хооронд байгуулсан гэрээ⁵⁸ хамаарах бөгөөд тэд өв залгамжлагчийг нас барсны дараа өв хөрөнгийн тодорхой хэсгийг гэрээнд заасны дагуу авч ашиглаж,

⁵⁴ Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй (Олон улсын хувийн эрх зүйн хүрэн дэх судалгаа). Уб., 2018. 87 дахь тал

⁵⁵ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 95 дахь тал

⁵⁶ Мөн тэнд. 78 дахь тал

⁵⁷ Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 10 дахь тал

⁵⁸ Монгол Улсын Иргэний хуулийн 191 дүгээр зүйлийн 191.3 дахь хэсэг

захиран зарцуулдаг⁵⁹. Өв залгамжлалын гэрээ нь иргэний хуульд тусгагдаагүй, хэдийгээр хэрэгжих боломжтой боловч зарим талаараа гэрээслэлтэй төстэй харилцаа юм. Тэгвэл өв залгамжлах асуудал нь хуульд зааснаар болон гэрээслэлийн журмаар гэсэн хоёр төрлөөс гадна өөр нэг төрөл байж болох Өв залгамжлах гэрээ гэсэн ойлголтыг улс орнууд хууль тогтоомждоо бататгасан байдаг.⁶⁰ Гэхдээ Өв залгамжлах гэрээ нь өвлүүлэгч амьд ахуйдаа гэрээнд заасан эд хөрөнгийг захиран зарцуулах тухай ойлголт бөгөөд өвлүүлэгчийг нас барсан тохиолдолд буюу ирээдүйд хэрэгжих гэрээ юм. Харин Доктор Ц.Оюунаа өвлөгдөх хөрөнгийг хэлэлцээрийн журмаар хуваарилах талаарх дэвшүүлсэн санаагаа дэмжих зорилгоор жишээ татан тайлбарласан бөгөөд энэхүү жишээ нь өв залгамжлагчид өөр хоорондоо харилцан тохиролцож өв хөрөнгийг хуваарилж болохыг харуулж байна. Жишээ нь, эхний ээлжийн гурван өв залгамжлагч автомашин, банк дахь хадгаламж болон хуучны эдлэлийн цуглуулгын эзэмшигчид болно. Тэдний хүн тус бүр нь ерөнхий журмаараа энэхүү эд хөрөнгийн эрхийн 1/3-ийн хувь хэмжээг эд зүйлс болгоноос эзэмших эрхтэй. Гэвч тэд цаашид өөр хоорондоо хэлэлцээр байгуулан, түүнийхээ дагуу нэг нь автомашинаа, нөгөөх нь хадгаламжаас мөнгөө, гурав дахь нь цуглуулгыг тус тус эзэмшигч болж, эсхүл нэг нь хуучны эдлэлийн цуглуулгын эзэмшигч бөгөөд нөгөө хоёр нь автомашин болон мөнгөн хадгаламжийн хамтран эзэмшигчээр тус тус үлдэж болно.⁶¹ Энэ тохиолдолд өв залгамжлагчид өөр хоорондоо тохиролцож чадаагүй бол маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй.

Шүүхийн журмаар өвлөгдөх хөрөнгийг хуваарилах.

Өвлөгчид эд хөрөнгийг хэмжээ, нэр, төрөл болон бусад шалтгаан зааж маргавал шүүхийн шийдвэрээр хуваарилж болно. Энэ талаар Иргэний хуулийн 532 дугаар зүйлийн 532.1 дэх хэсэгт зааснаар шүүх шийдвэрлэхээр зохицуулж өгсөн.

Эвлэрүүлэн зуучлах аргаар өвлөгдөх хөрөнгийг хуваарилах.

Өвлөгдөх хөрөнгийг шүүхийн бус аргаар буюу эвлэрүүлэн зуучлалын аргаар хуваарилж болохоор байна. Тухайлбал, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн эрхийн маргаан болон гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэнэ.”, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар

⁵⁹ Б.Улаанбаатар, «Өв залгамжлалын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага, хэтийн төлөв,» Эрх зүй судлал 2016.шаардлага, хэтийн төлөв 210 дахь тал

⁶⁰ Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй (Олон улсын хувийн эрх зүйн хүрэн дэх судалгаа). Уб., 2018. 183 дахь тал

⁶¹ Мөн тэнд, 136 дахь тал

зүйлийн 67.1.4-д шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эвлэрүүлэн зуучлагчийг сануулах үүрэгтэй, мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7-д хэргийн оролцогчид эвлэрүүлэн зуучлах журмаар хэрэг шийдвэрлүүлэх хүсэлт гаргах эрхтэй гэж тус тус заасан байдаг. Эндээс үзэхэд эвлэрүүлэн зуучлах аргаар өвлөгдөх эд хөрөнгийг хуваарилж зохицуулалт харагдаж байна.

III. Өвлөгдөх хөрөнгийг гэрээгээр хуваарилах тухайд

A. Өвлөгдөх хөрөнгийг хуваарилах гэрээ

Өвлөгдөх хөрөнгийг хуваарилах талаар өвлөгчдийн хооронд байгуулах гэрээнд иргэний эрх зүй дэх гэрээний чөлөөт байдлын зарчимд нийцэх ёстой. Энэхүү зарчмын хүрээнд оролцогч нь гэрээний төрөл, агуулга, гэрээ байгуулах эсэхээ хэнээс ч түүний дотор төрийн байгууллага албан тушаалтнаас хараат бусаар сонгох эрхтэй байна. Өөрөөр хэлбэл, иргэний эрх зүйн харилцааны оролцогч нь хууль тогтоомжоор хориглоогүй агуулгаар гэрээ байгуулах эрх чөлөөтэй.⁶² Гэрээ гэдэг нь иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэгдсэн, хоёр ба түүнээс дээш этгээдийн хооронд хийсэн тохиролцоо⁶³ бөгөөд өвлөгчид хоорондоо өвийг хэрхэн хуваан авах тохиролцоо нь Иргэний хуулийн 191 дүгээр зүйлийн гурав, 43 дугаар зүйлийн 43.2.1-д нийцсэнээр Өвлөгдөх хөрөнгийг хуваарилах талаар өвлөгчдийн хооронд байгуулах гэрээ болно. Ер нь хуульд тодорхой заагаагүй боловч зарчмыг нь тусгаж өгсөн учраас өв залгамжлалд оролцож байгаа бүх өвлөгчид хэлэлцэн зөвшилцөх, хуульд заасан болон гэрээслэлээр өвлөгч бүр ноогдвол зохих хэмжээгээр нь хоорондоо шийдэх учиртай.⁶⁴

Өвлөгдөх эд хөрөнгө хуульд зааснаар болон гэрээслэлээр хэд хэдэн өв залгамжлагчдын эзэмшилд очиж байгаа тохиолдолд тэр нь өв нээгдсэн өдрөөс эхлэн өв залгамжлагчдын нийтийн эд хөрөнгийн дэглэмтэй болдог, энэ ч утгаараа “өв залгамжлагчдын нийтийн өмч”⁶⁵ гэсэн ойлголт гарч ирдэг. Өөрөөр хэлбэл бүрэн эрх залгамжлагчдад хуваарилагдах гэж буй эд хөрөнгө нь тэдгээрийн өмчлөлд шилжээгүй байх үедээ нийтийн (өв залгамжлагчдын) эд хөрөнгө гэж тооцогдож байгаа учир ийнхүү нэрлэжээ. Өв залгамжлагчдад шилжиж буй эд хөрөнгийн нийтийн шинж чанартай дэглэм нь хамтран эзэмшигчдийн хоорондын хэлэлцээрээр өөрчлөгдөж болно.⁶⁶ Өөрөөр хэлбэл хууль

⁶² Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүй I Ерөнхий анги Уб., 2020. 35 дахь тал

⁶³ Хууль зүйн яам, Иргэний эрх зүйн гарын авлага Уб., 2013. 31 дэх тал

⁶⁴ Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй (Олон улсын хувийн эрх зүйн хүрэн дэх судалгаа). Уб., 2018. 137 дахь тал

⁶⁵ Мөн тэнд. 136 дахь тал

⁶⁶ Мөн тэнд

ёсны өв залгамжлагчид өөр хоорондоо өв хөрөнгийн аль хэсгийг авахаа хэлэлцэн тохиролцож болно гэсэн санаа дэвшүүлсэн байна.

Доктор Т.Мөнхжаргал өөрийн бүтээлдээ өвлөгдсөн эд хөрөнгийг Өв залгамжлалд оролцсон бүх өвлөгчид ямар нэгэн маргаангүйгээр өөр хоорондоо тохиролцож, хууль ёсны ба гэрээслэлээр өвлөгч бүрд оногдволзохих хэмжээгээр хуваарилах, өвлөгчидэд хөрөнгийг хэмжээ, нэр, төрөл болон бусад шалтгаан зааж маргавал шүүхийн шийдвэрээр тус тус хуваарилна хэмээн тодорхойлжээ.⁶⁷ Доктор Ц.Оюунаа болон доктор Т.Мөнхжаргал нарын өвлөгдөх хөрөнгийг хуваарилах талаарх тодорхойлолтуудын шинжийг үзэхэд өвлүүлэгчийн өв хөрөнгө бодитой, ямар нэг эрхийн зөрчилгүй байх, өв хүлээн авагчид нь хууль ёсны өвлөгчид байх, тэдгээр нь өөр хоорондоо өвийн талаар ямар нэгэн маргаангүйгээр хэлэлцэн тохиролцсон байх урьдчилсан нөхцөлийг шаардаж байна. Өв нээгдсэний дараа гэнэт бий болох урьдчилан тооцох боломжгүй байсан эрх зүйн үр дагавар нь тухайн аж ахуйн нэгжид сөргөөр нөлөөлөх боломжтой. Иргэний хуулийн өв залгамжлалын хэсэгт өвлүүлэгчийг оролцуулсан заавал биелүүлэх шинжтэй өв залгамжлалын гэрээг тусгаагүй байгаа учраас энэ зохицуулалт ихээхэн ач холбогдолтой.⁶⁸

Өв хүлээн авагчдын чөлөөт сонголтын зарчимд өв хүлээн авагч хэний ч шахалт, хавчилт, нөлөөлөлгүйгээр өвийг хүлээн авах, эсэх талаар сонголт хийх эрхтэй байдаг. Доктор Ц.Оюунаа болон доктор Т.Мөнхжаргал нар өвлөгдөх хөрөнгийг хуваарилах талаар хууль ёсны өв залгамжлагчид өвийг хэлэлцэн тохиролцож өөрчилж болно гэж тодорхойлсон байдаг. Энэхүү тодорхойлолт нь Өв хүлээн авагчдын чөлөөт сонголтын зарчимд үндэслэн өвийг хуваарилж буй үйл явдал гэж дүгнэж болохоор байна.

Өв залгамжлал нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогч бүхий л этгээдэд хамаарах ойлголт биш харин иргэн хүний хувьд хамаарах хууль зүйн дагуу хийх үйлдэл юм. Аливаа эрх зүйн харилцаанд оролцогч талууд байх учиртай ба энэ талаар доктор Б.Улаанбаатар өв залгамжлалын харилцааны субъектийг тодорхойлсон байдаг.⁶⁹ Өв залгамжлалын эрх зүйн харилцааны оролцогчдын талаар авч үзье. Өвлүүлэгч нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогч болохын хувьд гадаадын болон Монгол Улсын иргэн, харьяалалгүй этгээд, өвлөгч нь хуулийн дагуу өвлөх эрхтэй байдаг хууль ёсны өвлөгчид болон гэрээслэлд дурдагдсан нэр бүхий этгээд хамаарна. Харин өвлөлийн

⁶⁷ Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 78-79 дэх тал

⁶⁸ Монгол Улсын иргэний хуулийн тайлбар, 2022. 323 дахь тал

⁶⁹ Б.Улаанбаатар, Гэрээслэлээр өв залгамжлалын эрх зүйн шинэчлэлтийн тулгуур асуудал. Уб., 2018. 50 дахь тал

зүйлд өвлүүлэгчийн эд хөрөнгө, эрх хамаарна.⁷⁰ Гэрээний оролцогч талууд нь зөвхөн хууль ёсны өвлөгчид байх ба өв залгамжлалын гэрээ байгуулах тохиолдолд өвлүүлэгч гэрээний нэг тал болно, гэрээний зүйл нь өв хөрөнгө болно. Иймд өвлүүлэгчийн хүсэл зоригийг тооцох зарчим, өв хүлээн авагчдын чөлөөт сонголтын зарчимд үндэслэн хууль ёсны өв залгамжлагчид өвийг хуульд зааснаар болон гэрээслэлийн журмаар өвлөхөөс гадна “Өвлөгдөх хөрөнгийг хуваарилах гэрээ”-ээр хуваарилж болохоор байна. Энэ талаар хууль тогтоогч Иргэний хуулийн 191 дүгээр зүйлд Өвлөгдөх эд хөрөнгийн талаар байгуулах гэрээний хэрэгжих суурь нөхцөлийг хуульчилж өгсөн. Тухайлбал, мөн зүйлийн 3 дахь хэсэгт Өвлөгдөх хөрөнгөөс ногдох хэсгийн талаар хууль ёсны өвлөгчдийн хооронд байгуулсан гэрээ нь хүчин төгөлдөр байхаар тусгажээ.

Б. Өвлөгдөх хөрөнгийг хуваарилах талаар өвлөгчдийн хооронд байгуулсан гэрээг нотариатаар гэрчлүүлэх нь

Өв залгамжлалын эрх зүйд нотариатчийн оролцоо нэн чухал үүрэгтэй бөгөөд манай улс Иргэний хууль, Нотариатын тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 171 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Нотариатын үйлдэл хийх заавар”-д нотариатчийн өв залгамжлалтай холбоотой хийх үйлдлийн талаар тусгасан байдаг. Нотариатч нь өв залгамжлалын эрх зүйн харилцаанд гэрээслэл гэрчлэх, өвлөх эрхийн гэрчилгээ олгох, өвлөгдөх эд хөрөнгөд эрхлэн хамгаалалт тогтоох гэсэн гурван төрлийн үндсэн үүрэгтэй оролцдог.

Нотариатын гүйцэтгэх үндсэн үүргүүдийн нэг нь өв залгамжлалын эрх, гэрээслэлийг гэрчилнэ.⁷¹ Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний хууль, Нотариатын тухай хуульд өвлөгдөх хөрөнгийг хуваарилах талаар өвлөгчдийн хооронд байгуулах гэрээг нотариатаар гэрчлүүлэх эсэх талаар тусгайлсан зохицуулалт байдаггүй. Гэхдээ өвлөгдөх хөрөнгийг хуваарилах гэрээг холбогдох этгээдээр гэрчлүүлэх хэрэгцээ, шаардлага байна.

Өв нээгдэх нь өвийг хүлээн авах боломжийг өвлөгчид үүсгэдэг хууль зүйн факт юм.⁷² Өв хүлээн авахын өмнө хүсэл зоригоо тодорхойлох шаардлагатай байдаг ба өв залгамжлах эрхийг хэрэгжүүлэх нь өв залгамжлагчид хүсэл зоригоо илэрхийлсний үр дүнд л байх боломжтой байдаг.⁷³ Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй

⁷⁰ В.Оюумаа, «Өв залгамжлалын эрх зүйн харилцаанд нотариатчийн гүйцэтгэх үүрэг.»

⁷¹ Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 51 дэх тал

⁷² Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 58 дахь тал

⁷³ Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй (Олон улсын хувийн эрх зүйн хүрэн дэх

иргэний хуульд өвлөгчдийн хүлээн авсан эд хөрөнгийг, өв нээгдсэн өдрөөс эхлэн өвлөгчид шилжсэн гэж үзнэ гэжээ.⁷⁴ Ямар нэгэн этгээд өөр этгээдийн эд хөрөнгийн өвлөгч болсон тухай мэдээллийг нийтэд хүртээх арга зам нь нотариатчаас олгодог тусгай баримт бичиг болох “Өвлөх эрхийн гэрчилгээ” бөгөөд энэ нь өвлөх журмаар эд хөрөнгийн эрх олж авахын баталгаа болдог.⁷⁵ Энэ баримт бичгийн хууль зүйн ач холбогдол нь өвлөх эрхийг баталгаажуулах шинж чанартай, түүнийг нийтийн журмаар авах ба олгодогт оршино.⁷⁶

Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсэгт “Өвлөх эрхийн гэрчилгээнд өвлөгдөх эд хөрөнгө, ногдох хэсгийг тодорхой заах бөгөөд түүнийг тогтоохдоо Иргэний хуулийн 522, 531, 533 дугаар зүйлийг баримтална” гэжээ. Хууль ёсны буюу гэрээслэлээр өв хүлээн авагчид өвийг хүлээн авснаар өв залгамжлалын эрх зүйн харилцаа дуусгавар болно. Өвлүүлэгчийн эд хөрөнгө өвлөгчдөд шилжиж тэдэнд өмчлөх эрх шинээр үүсэж, түүнтэй холбоотой эрх, үүрэг бий болно гэсэн үг юм.⁷⁷

Өвийн гэрчилгээнд өвлүүлэгч, өв нээгдсэн үе, өвийн эд хөрөнгө, өвлөгчид, түүнд хамаарах өвийн хувь хэмжээг заасан⁷⁸, өөрөөр хэлбэл өвлөгчид гэрчилгээндээ өвлөгдөх хөрөнгийн хуваарилалтын хэмжээгээ тохиролцож, тусгасан байхыг шаардаж байна. Хууль тогтоогч Нотариатын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.4-д нотариатын үйлдэлд өвлөх эрхийн гэрчилгээ олгох, мөн хуулийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсэгт өвлөх эрхийн гэрчилгээг олгоход үндэслэх баримт бичгүүдийг тогтоож өгснөөс гадна Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 171 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Нотариатын үйлдэл хийх заавар”-ын 8 дугаар зүйлд өвлөх эрхийн гэрчилгээг олгох зааврыг тус тус тодорхойлжээ.

Гэрээслэгч зарим эд хөрөнгийг гэрээсэлсэн тохиолдолд, хууль ёсны бусад өвлөгчид энэхүү гэрээгээр гэрээслэлээс үлдсэн өв хөрөнгийг өвлөгдөх хөрөнгийг хуваарилах гэрээний дагуу хоорондоо хэлэлцэн, тохиролцож авах эрх нь нээлттэй.⁷⁹ Аливаа эрх зүйн харилцаа хэрэгжихийн тулд суурь урьдчилсан нөхцөлүүд бүрдсэн байх учиртай бөгөөд энэ тохиолдолд өвлөх эрхийн гэрчилгээ гарсан

судалгаа). Уб., 2018. 124 дэх тал

⁷⁴ Монгол Улсын Иргэний хуулийн 527 дугаар зүйлийн 527.3 дахь хэсэг

⁷⁵ Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй (Олон улсын хувийн эрх зүйн хүрээн дэх судалгаа). Уб., 2018. 134 дэх тал

⁷⁶ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 157 дахь тал

⁷⁷ Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй. Уб., 2009. 65 дахь тал

⁷⁸ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 162 дахь тал

⁷⁹ Монгол Улсын Иргэний хуулийн 521 дүгээр зүйлийн 521.1 дэх хэсэг

байхыг шаардана. Өвлөгдөх хөрөнгийг гэрээгээр хуваарилах аргыг хэрэглэхдээ хууль ёсны өвлөгчид өв нээгдсэнээс хойш өвлөх эрхийн гэрчилгээ гарсны дараах харилцаан дээр өөр хоорондоо тохиролцсон байхыг шаардаж байна.

Энэхүү гэрээг бичгээр үйлдэн нотариатаар гэрчлүүлсэн байх учиртай бөгөөд өвлөх эрхийн гэрчилгээгээр эд хөрөнгийн эрх шилжихтэй холбоотой асуудал яригдана. Тухайлбал, гэр ахуйн шинжтэй зурагт, компьютер, аяга, тавилга зэргийг заавал өвлөх эрхийн гэрчилгээнд тусгаж эрх бүхий байгууллагад хандаж эрх шилжүүлэх шаардлагагүй бөгөөд энэ талаар өөр хоорондоо тохиролцоход л болно. Харин үл хөдлөх хөрөнгө болох орон сууцны эзэмших эрхийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийн эрхийн гэрчилгээ, хөдлөх хөрөнгө болох автомашин, мал зэргийг заавал өвлөх эрхийн гэрчилгээнд тусгаж эрх бүхий байгууллагад хандан эрх шилжүүлэх замаар шинэ өмчлөгчид шилжих учир энэ шилжихтэй холбогдсон суурь харилцаа болох гэрээг заавал нотариатаар гэрчлүүлэх шаардлага энд үүснэ.

Өвлөгчид өвлөх эрхийн гэрчилгээ гарсны дараа ийнхүү өөр хоорондоо өвлөгдөх хөрөнгийн талаар тохиролцож, өвлөгдөх хөрөнгийг хуваарилах суурь харилцаа нь “Өвлөгдөх хөрөнгийг хуваарилах гэрээ”-ний дагуу хэрэгжих ёстой учир энэхүү нэршлийг хуульд тусган өгөх шаардлагатай хэмээн үзэж байна. Өвлөгдөх хөрөнгийг хуваарилах гэрээ нь шинэ ойлголт бөгөөд гэрээний оролцогч, гэрээний зүйл, гэрээний хязгаарлалт, гэрээ хүчин төгөлдөр бус болох нөхцөл зэрэг зүйлийг цаашид дэлгэрүүлэн судлах шаардлага гарч байна. Өвлөгдөх хөрөнгийг хуваарилах гэрээ нь хугацаагүй хэрэгжих бөгөөд энэ талаар хэт богино, эсхүл хэт урт хугацаа тогтоож өгөх нь төдийлөн ач холбогдолгүй юм.

IV. Өвлөгдөх хөрөнгийг хуваарилах асуудлаар зарим орны туршлага: Харьцуулсан судалгаа (БНСУ, Япон Улс)

A. Өвлөгдөх хөрөнгийг харилцан тохиролцох замаар хуваарилах харилцаа

БНСУ нь өв залгамжлах харилцааг иргэний хуулиараа зохицуулдаг бөгөөд өвлөгдөх хөрөнгийг хуульд зааснаар болон гэрээслэлээр хуваарилахаас гадна хэлэлцээрийн журмаар хуваарилдаг байна.⁸⁰ Гэрээслэл үйлдээгүй тохиолдолд өвлөгчид хэлэлцээрийн журмаар өвлөгдөх хөрөнгийг хуваарилж болох ба хууль ёсны өвлөгчид өөр хоорондоо харилцан тохиролцож өвлөгдөх хөрөнгийг хуваан авах хүсэлт гаргасны дагуу хийгдэх ажиллагаа юм. Өөрөөр

⁸⁰ БНСУ-ын иргэний хуулийн 1013 дугаар зүйл.

хэлбэл, өв залгамжлагчид өвлөгдөж буй эд хөрөнгийг хэн өмчлөх, өвлөхөөс татгалзах эсэх зэргийг харилцан тохиролцож тогтоох эрхтэй. Хамтран өвлөгчдийн аль нэг нь оролцоогүй тохиолдолд уг гэрээ хүчин төгөлдөр бус байна. Хэрэв энэ хэлэлцээрт хууль ёсоор өвлөх гуравдагч этгээд оролцоогүй тохиолдолд хэлэлцээрийн талуудаас гуравдагч өвлөх эрхтэй этгээд хөрөнгийн хэмжээнээс зохих хэмжээгээр нөхөн төлбөр шаардах эрхтэй байна. Хэлэлцээрээр хөрөнгийг хуваарилахдаа эхний ээлжид талууд амаар тохиролцох боловч тэдгээрийн хооронд ирээдүйд гарах маргаанаас урьдчилан сэргийлэхийн тулд Өвлөгдсөн эд хөрөнгийг хуваах гэрээ байгуулах шаардлагатай.

Япон Улсад тусгайлсан өв залгамжлалын тухай хууль байдаггүй бөгөөд өв залгамжлалын эрх зүйн харилцаа тэр дундаа өвлөгдөх хөрөнгийг хэрхэн хуваарилах тухай зохицуулалтыг иргэний хуулийн 5 дугаар бүлэгт тусгасан байдаг.⁸¹ Япон улсын Иргэний хуульд хуульд зааснаар⁸², гэрээслэлээр өвлөх⁸³, хэлэлцүүлэг өрнүүлэх замаар гэрээслэлээр хориглосноос бусад тохиолдолд эд хөрөнгийг хуваарилах⁸⁴ болон шүүхийн журмаар хуваарилж болдог.

Хэлэлцүүлэг өрнүүлэх замаар гэрээслсэн эд хөрөнгийг хуваарилах талаар “ATOM Legal Professional Corporation” цахим хуудсанд дэлгэрэнгүй тайлбарласан байдаг.⁸⁵ Тухайлбал, Зарим тохиолдолд өвлөгдөх хөрөнгийг хуваарилах нь талаар гэрээслэлд урьдчилан тодорхойлсон байдаг. Хэрэв гэрээслэлд энэ талаар тодорхойлоогүй бол өвлөгчид хэлэлцэн тохиролцох зорилгоор хэлэлцүүлэг өрнүүлнэ. Хэлэлцүүлгийн явцад хэлэлцээрийн оролцогчид өв хөрөнгийн талаар ямар нэгэн маргаангүй тохиролцож гэрээслэлээр хориглосноос бусад тохиолдолд гэрээгээр өвлөн авсан эд хөрөнгийг хэдийд ч хувааж болно. Хэрэв ийнхүү тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд хамтран өвлөгч тус бүр өмгөөлөгч томилж, гэр бүлийн шүүхэд өв залгамжлах эд хөрөнгийг хуваах хүсэлт гаргаж болно гэжээ.

БНСУ-ын Иргэний хууль дахь өвлөгдөх хөрөнгийг хэлэлцээрийн журмаар хуваарилах, Япон Улсын Иргэний хууль дахь өвлөгдөх хөрөнгийг хэлэлцүүлэг өрнүүлэх замаар хуваарилах аргууд нь хууль ёсны өвлөгчид нийтийн дэглэмтэй⁸⁶ эд хөрөнгийг өөр хоорондоо ямар

⁸¹ Япон улсын иргэний хуулийн орчуулга, орч. Б.Урангоо, Уб., 2018. 224 дэх тал.

⁸² Япон улсын иргэний хуулийн 900 дугаар зүйл

⁸³ Мөн хуулийн 906 дугаар зүйл

⁸⁴ Мөн хуулийн 907 дугаар зүйл

⁸⁵ “English lawyers Japan,” *English lawyers Japan*. <https://englishlawyersjapan.com/how-is-inheritance-divided-between-co-heirs-in-japan/>

⁸⁶ Ц.Оюунаа 2017 онд гаргасан “Өв залгамжлалын эрх зүй, Олон улсын хувийн эрх зүйн хүрэн дэх судалгаа” бүтээлдээ “нийтийн эд хөрөнгийн дэглэм гэж өв

нэгэн маргаангүй хэлэлцэн тохиролцсон байх урьдчилсан нөхцөлийг агуулж байна. Монгол Улсын Иргэний хуулийн 191 дүгээр зүйлийн 191.3 дахь хэсэгт зааснаар өвлөгдөх хөрөнгөөс өөрт ногдох хэсгийн талаар хууль ёсны өвлөгчдийн хооронд байгуулсан гэрээ нь хүчин төгөлдөр байхаар тусгагдсан бөгөөд уг гэрээ байгуулах урьдчилсан нөхцөл нь БНСУ болон Япон улсын дээрх хэлэлцээр, хэлэлцүүлгийн журамтай адил талууд өөр хоорондоо маргаангүй хэлэлцэн тохиролцсон байх шинжийг агуулж байна.

Б. Өвлөгдөх хөрөнгийн үнэ цэнийг хуваах зарчим

БНФУ нь өвлөгдөх хөрөнгийн үнэ цэнийг чухалчлан үздэг шинэлэг тал ажиглагдсан төдийгүй 2016 онд Иргэний хуульдаа өвлөгдөх хөрөнгийг үнэ цэнийг бууруулахгүй байх зохицуулалтыг хийн өгсөн нь дээрх харьцуулан судалсан орнуудын өв залгамжлалын эрх зүйн харилцаанаас ялгаатай тал ажиглагдлаа.

Өвлөгдөх хөрөнгийн үнэ цэнийг хуваах зарчмыг манай улсын хувьд энэ асуудлыг тайлбарласан, хуульд тусгайлан зохицуулагдаагүй бөгөөд БНФУ-ын туршлага дээр үндэслэн тайлбарлахаар зорилоо. БНФУ-д өв залгамжлалын тусдаа хууль байдаггүй бөгөөд өв залгамжлалын эрх зүйн харилцаа, өвлөгдөх хөрөнгийг хуваарилах гол зохицуулалтыг Иргэний хуульдаа тусгаж өгсөн. БНФУ-ын Иргэний хуульд өвлөгдөх хөрөнгийг зургаан арга буюу хуульд зааснаар⁸⁷, гэрээслэлээр⁸⁸, хэлэлцээр⁸⁹, шүүхийн журмаар⁹⁰, хандиваар⁹¹ болон гэрээгээр⁹² хуваарилдаг байна. Гэрээслэлээс бусад аргаар өвлөгдөх хөрөнгийг хуваарилах тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг чухалчлан авч үзэж, аль болох бодитоор хуваарилахыг дэмждэг. Тус улс нь өв залгамжлалын эрх зүйдээ өв хөрөнгийн үнэ цэнийг хадгалах нь чухал үүрэгтэй гэж үздэг бөгөөд “Өвлөгдөх хөрөнгийн үнэ цэнийг хуваах зарчим”-ын дагуу өв хөрөнгийг зохистой хуваарилах талаар иргэний хуульдаа дараах удирдамжийг оруулж өгсөн.⁹³ Үүнд:

- *Бодит хуваарилалт (Partage en Nature)*⁹⁴

Бодит хуваарилалт нь өв хөрөнгийн бодит хуваарилалтыг дэмжих залгамжлагчдын нийтийн өмч” гэж тодорхойлсон.

⁸⁷ БНФУ-ын Иргэний хуулийн 734 дүгээр зүйл

⁸⁸ БНФУ-ын Иргэний хуулийн 895 дугаар зүйл

⁸⁹ БНФУ-ын Иргэний хуулийн 835 дугаар зүйл

⁹⁰ БНФУ-ын Иргэний хуулийн 840 дүгээр зүйл

⁹¹ БНФУ-ын Иргэний хуулийн 931 дүгээр зүйл

⁹² БНФУ-ын Иргэний хуулийн 815-2 дугаар зүйл

⁹³ «Héritage & Succession,» in *Quand a lieu le partage d'une succession ?* /Өвлөгдөх хөрөнгийг хэзээ хуваарилдаг вэ?/ (02 28 2024). <https://www.heritage-succession.com/article-quand-a-lieu-le-partage-dune-succession.html#:~:text=Il%20convient%20de%20pr%C3%A9ciser%20que,des%20droits%20dans%20une%20succession.des%20droits%20dans%20une%20succession.>

⁹⁴ Partage en Nature – францаар бодит хуваарилалт гэж орчуулагдана.

бөгөөд ингэснээр үл хөдлөх хөрөнгө эсвэл гэр бүлийн бизнестэй холбоотой үнэт зүйлсийг зарахгүйгээр тухайн өв залгамжлагчид шилжүүлэх боломжийг олгодог. Жишээлбэл, өв хөрөнгийн нэг хэсэг нь орон сууц байвал тухайн өв залгамжлагчид хөрөнгийг зарж, хувааж өгөхөөс илүүтэйгээр тус хөрөнгийг үнэлж, бусад өв залгамжлагчдад нөхөн олговор олгох замаар хуваарилалт хийж болно. Тус улсын Иргэний хуулийн 815 дугаар зүйлд “Хөрөнгийг хуваарилах үед газрыг хэсэгчилж хуваах, эзэмшлүүдийг салгах зэргээс зайлсхийх ёстой” гэж зааснаас үзэхэд хөрөнгийг бодит байдлаар хуваахыг дэмждэг нь ажиглагдаж байна.

- *Нөхөн төлбөр (Soulte)*⁹⁵

Зарим хөрөнгийг яг тэнцүү хуваах боломжгүй үед нөхөн төлбөрийг ашиглана. Жишээлбэл, нэг өв залгамжлагч илүү үнэтэй хөрөнгө авах тохиолдолд бусад өв залгамжлагчдад мөнгөн нөхөн төлбөр олгож болно. Ингэснээр өвлөгдөх хөрөнгийн үнэлгээг алдуулахгүйгээр өв залгамжлагчид хооронд тэгш бус үл хөдлөх хөрөнгийн зөрүүг нөхөн олгодог.

- *Үнэлгээ (Évaluation)*⁹⁶

Хөрөнгийн үнэлгээг зөв хийж, зарим нэг хэсгийг үнэгүйдүүлэхээс сэргийлэх зорилготой. БНФУ-д өв хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоохын тулд хөрөнгийн мэргэшсэн үнэлгээний төвөөр үнэлгээ хийлгэх бөгөөд ингэснээр өв хөрөнгийн үнэ цэнийг бууруулахгүй, зөв хуваарилахад тус болно.

- *Түр эзэмшил (Indivision Temporaire)*⁹⁷

Шаардлагатай тохиолдолд өв залгамжлагчид тодорхой хугацаанд өв хөрөнгийг хамтран эзэмших түр эзэмшлийн хэлбэрийг ашиглаж болдог. Энэ нь үл хөдлөх хөрөнгө болон бизнесийн хөрөнгө зэрэг өв хөрөнгийг зах зээлийн нөхцөл сайжиртал эсвэл зөв хуваарилалт хийх боломж бүрдэх хүртэл зарахгүйгээр өв хөрөнгийг хадгалах боломжийг олгоно.

- *Мэргэжлийн үнэлгээгээр үнэлүүлж шүүхийн журмаар худалдах (Expertise et Vente Judiciaire)*⁹⁸

Өв хөрөнгийг бодит байдлаар хуваарилах, эсвэл харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй үед шүүхийн замаар худалдан борлуулах шийдвэр гаргаж болох ба шүүхийн шийдвэр нь тухайн өв

⁹⁵ Soulte – францаар тэнцвэр гэж орчуулагдах бөгөөд хөрөнгийг хуваах боломжгүй тохиолдолд нөгөө талд нөхөн төлбөр өгөх замаар өвийн харилцааг тэнцүүлнэ.

⁹⁶ Évaluation- францаар үнэлгээ гэж орчуулагдана.

⁹⁷ Indivision Temporaire – францаар түр зуурын хамтын өмчлөл гэж орчуулагдана.

⁹⁸ Expertise et Vente Judiciaire – францаар мэргэжлийн үнэлгээгээр үнэлүүлж шүүхийн журмаар худалдах гэж орчуулагдана.

хөрөнгийн үнэлгээг зөв тодорхойлж, үнэ цэнийг бууруулахгүйгээр борлуулах боломжийг олгодог.

- *Гэр бүлийн бизнесийн хуваарилалт (Partage de l'Entreprise Familiale)*⁹⁹

БНФУ-ын гэр бүлийн бизнест өв хөрөнгийн үнэ цэнийг хадгалах тусгай хамгаалалтууд байдаг. Тухайн гэр бүлийн бизнесийг удирдаж байгаа өв залгамжлагчид шилжүүлэх, бусад өв залгамжлагчдад нөхөн олговор олгох замаар бизнесийн үйл ажиллагааг цааш үргэлжлүүлэх боломжийг бүрдүүлж, бизнесийн үнэ цэнийг бууруулахгүй байх боломжтой.

Манай улсын хувьд өвлөгдөх хөрөнгийг Иргэний хуулийн 532 дугаар зүйлийн 532.1 дэх хэсэгт зааснаар өв залгамжлалд оролцсон бүх өвлөгчид хэлэлцэн зөвшөөрөлцөж, хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөгч бүрт оногдвол зохих хэмжээгээр хуваарилдаг. Өвлөгч бүрт оногдвол зохих хэмжээг зөвхөн өвийн нийт хэмжээнээс тооцох хувь, эсхүл мөнгөн хэлбэрээр үнэлж дүгнэх нь учир дутагдалтай. Харин өв хөрөнгийн үнэ цэнийг зөв, үр ашигтай байдлаар тодорхойлсноор БНФУ-ын туршлагын хуваарилалтыг хийх бүрэн боломжтой болно. Гэтэл практик дээр өв хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлохоос илүүтэйгээр хувь хэмжээнд нь ач холбогдол өгч, бялуу хуваах зарчмаар хуваарилж буй тохиолдол ажиглагдлаа. Тухайлбал, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 568 дугаар магадлалд¹⁰⁰ маргааны зүйл болж буй үйлчилгээний зориулалттай гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын үл хөдлөх хөрөнгийг дөрвөн хууль ёсны өвлөгчдөд дөрөв хувааж, талийгаачид ногдох хэсгийг дахин дөрөв хувааж, нэхэмжлэгч 1/16 буюу 6.25 хувийг өмчлөх эрхтэй гэж шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл, тухайн үйлчилгээний зориулалттай, цаашид ашиг, орлого олох зорилготой үл хөдлөх эд хөрөнгөний хувь заяаны талаар дүгнэлт өгөлгүй шууд хувааж хэргийг шийдвэрлэсэн байна. Энэ тохиолдолд өвийг хэрхэн хуваарилж авах тухай асуудал хөндөгдөх бөгөөд үнэлгээнд суурилсан мөнгөн хэлбэрээс өөрт ногдох хэсгийг авах, эсхүл ирээдүйд олох орлогоос хувь хүртэх эсэх нь тодорхойгүй байна. Дээрх тохиолдолд Иргэний хуулийн 191 дүгээр зүйлийн 191.3, 532 дугаар зүйлийн 532.1 дэх хэсэгт зааснаар өвлөгчид өөр хоорондоо харилцан тохиролцож, өвлөгдөх хөрөнгийг хуваарилах бүрэн боломжтой боловч энэ талаар тогтсон нийтлэг гэрээний ерөнхий нөхцөл байхгүй. Хэрэв өвлүүлэгч

⁹⁹ Partage de l'Entreprise Familiale – францаар гэр бүлийн бизнесийн хуваарилалт гэж орчуулагдана.

¹⁰⁰ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 210/МА2019/00568 дугаар магадлал. https://shuukh.mn/single_case/12970?daterange=2019-01-01%20-%202019-11-10&id=2&court_cat=1&bb=1

амьд байсан бол энэхүү хэвийн үйл ажиллагаатай, үйлчилгээний зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг ийнхүү хуваан өгөх түүний хүсэл зориг байсан эсэх нь эргэлзээтэй. Нөгөө талаас гэр бүлийн гишүүд өөр хоорондоо өвлөгдөх хөрөнгийн талаар маргаантай байх нь зохисгүй юм.

БНФУ өвлөгдөх үл хөдлөх хөрөнгийг хууль ёсны өвлөгчид өвлүүлэхдээ бодитоор хуваарилахыг эрмэлздэг нь дээрх удирдамжаас харагдаж байгаа бөгөөд энэ нь тухайн үл хөдлөх хөрөнгийн үнэ цэн, үр ашиг болон ирээдүйд олох үр шимийг харгалзан үзэж буй явдал гэж ойлгож болно. Тухайлбал, өвлүүлэгч мэдээж гэр бүл, ураг төрлийн хүмүүст өв хөрөнгөө өвлүүлэх нь өөрийн эцсийн хүсэл байж болно. Гэхдээ өвлүүлэгч үйлдвэр эзэмшдэг байгаад уг үйлдвэрийг өөрийг нь нас барсны дараа устгах, мөнгөн хэлбэрээр бусдад хуваах гэсэн хүсэл зориг байхгүй байж болно. Тухайн үл хөдлөх хөрөнгө нь ашигтай ажилладаг хийгээд түүнийгээ өвлөгчид нь үргэлжлүүлээсэй гэсэн таамаглал байж болно. Өв залгамжлалын эрх зүй дэх “Өвлүүлэгчийн хүсэл зоригийг тооцох зарчим”-ын үндэслэл нь хуулиар өвлөгчдийн хүрээг хэрэв өвлүүлэгч өвөө өөрөө захиран зарцуулсан тохиолдолд хэнд үлдээх байсан, чухам хэнийг хууль ёсны өвлөгчид хамааруулах байсан гэсэн төсөөлөлд тулгуурласан байдаг.¹⁰¹ Тэгвэл өвлөгчид өвлөгдөх хөрөнгийн үнэ цэнийг алдагдуулахгүйгээр тухайн үйлдвэрийг ирээдүйд ашиг олох зорилгоор хамтран эзэмших, өөр хоорондоо харилцан тохиролцож түр эзэмших эсхүл бодитоор нэгэндээ шилүүлэх, шилжүүлж авсан өвлөгч нөхөн төлбөр өгөх замаар өвийн харилцаагаа тэнцүүлэх зорилгоор “Өвлөгдөх хөрөнгийн үнэ цэнийг хуваах зарчим”-ыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Эрх зүйн зарчим гэдэг нь нийгмийн амьдралын хэрэгцээ шаардлагыг хангаж, түүний харилцааг зохицуулахад баримтлах хууль зүйн үндсэн чиглэмж юм.¹⁰² Тэгвэл өвлөгдөх хөрөнгийн үнэ цэнийг хуваах зарчмыг хууль ёсны өвлөгчид өвлөгдөх хөрөнгийн иж бүрдэл, бүрэлдэхүүн, ирээдүйд олох үр ашиг, бодит үнэ цэнийг харгалзан үзэж хуваарилалт хийх гэж тодорхойлж болно.

Эх газрын эрх зүйн бүлд хамаарагддаг улс гүрнүүд, түүний дотор Монгол Улсад өв залгамжлал нь хууль зүйн мөн чанарын хувьд эрх залгамжлалд суурилдаг.¹⁰³ Гэхдээ доктор Б.Амарсанаагийн “гадаад улсын эрх зүйн шийдлийг хүлээн авахын тулд хоёр үндсэн асуудал тавигддаг байна. Нэгт, эрх зүйн хэм хэмжээ нь “экспортлож”

¹⁰¹ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 81 дэх тал

¹⁰² Д.Баярсайхан, Эрх зүйн онол. Уб., 2010. 66 дахь тал

¹⁰³ Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: асуудал, шинэчлэлт. Уб., 2017. 19 дэх тал

буй улсдаа хэрэгжих боломжтой, шударга ёсыг хангасан гэдэг нь нотлогдсон уу, хоёрт, хүлээн авах гэж байгаа улсын нөхцөл, эрх зүйн тогтолцоонд үйлчлэх боломжтой эсэхийг судлах ёстой байдаг¹⁰⁴ гэж дэвшүүлсэн санааг харгалзан үзэх шаардлагатай.

V. Өвлөгдөх хөрөнгийг гэрээгээр хуваарилахад Өвлөгдөх хөрөнгийн үнэ цэнийг хуваах зарчимтай холбогдох нь

Монгол Улсын Иргэний хуульд өвлөгдөх хөрөнгийг хуульд зааснаар болон гэрээслэлээр хуваарилах үндсэн хоёр аргыг хуульчилж өгсөн бөгөөд хууль ёсны өвлөгчид өөр хоорондоо гэрээ байгуулах замаар өвлөгдөх хөрөнгийг хуваарилах аргыг ашиглах эрх нь нээлттэй. Манай улсад өвлөгдөх хөрөнгийг гэрээгээр хуваарилах асуудлын талаар тусгайлсан судалгаа, бүтээл байдаггүй боловч зарим судлаачид өвлөгдөх хөрөнгийг өөр хоорондоо харилцан тохиролцоо замаар хуваарилах боломжтой гэж санаа дэвшүүлсэн байна. Бусад харьцуулсан улсын туршлага буюу БНСУ нь хэлэлцээрийн журмаар, Япон улс нь хэлэлцүүлгийн журмаар тус тус хууль ёсны өвлөгчид өвлөгдөх хөрөнгийг өөр хоорондоо харилцан тохиролцоо замаар хуваарилах аргыг хуульдаа тусган хэрэгжүүлдэг. Онол болон бусад улсын туршлагад үндэслэн өвлөгдөх хөрөнгийг хууль ёсны өвлөгчид өөр хоорондоо тохиролцон гэрээгээр хуваарилах бүрэн боломжтой байна. Энэхүү гэрээний гол зохицуулах зүйл нь өв хөрөнгийн үнэ цэнийг алдагдуулахгүйгээр хэрхэн хуваарилалт хийх асуудал юм.

Өвлөгдөх хөрөнгийг гэрээгээр хуваарилах явцад Өвлөгдөх хөрөнгийн үнэ цэнийг хуваах зарчим үйлчлэх учиртай юм. Учир нь, өвлүүлэгчийн хөрөнгийн нийт хэмжээ болон эрх, үүргийг нотариатаас олгох Өвлөх эрхийн гэрчилгээгээр тодорхойлсон бөгөөд өвлөгч өөр хоорондоо үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг алдагдуулахгүйгээр өөрт болон бусдад ашигтайгаар хэрхэн бодитоор хуваарилах талаарх тохиролцоо юм. Жишээлбэл, өвлүүлэгчийн эзэмшдэг байнгын үйл ажиллагаатай, ашиг олдог үйлдвэрийг хоёр хууль ёсны өвлөгчид дөрвөн жилийн хугацаатай гэрээгээр тохиролцон хамтран үргэлжлүүлж болно. Гэрээний хугацаа дуусах үед гэрээг сунгах, дуусгавар болгох эрх нь өвлөгчдөд нээлттэй. Газар эзэмших эрхийн хувьд жишээгээр тайлбарлавал, 5га хэмжээ бүхий газар өвийн бүрэлдэхүүнд байвал энэхүү газрын үнэ цэн таван өвлөгч 1га хэмжээгээр тус бүр хуваасан тохиолдолд мэдээж газрын үнэ цэн илт буурна. Өөрөөр хэлбэл, 5га хэмжээ бүхий газарт тариалан эрхлэх, 1га газарт тариалан эрхлэх нь ашигт байдлаараа ялгагдана. Хууль ёсны өвлөгчид гэр бүлийн, ураг төрлийн хүмүүс байдаг учир өвлөгдөх хөрөнгийн үнэ цэнийг бусдаас илүү сайн мэддэг учраас өөр хоорондоо харилцан тохиролцож

¹⁰⁴ Б.Амарсанаа, Харьцуулсан эрх зүй судлал (хоёр дахь хэвлэл). Уб., 2014. 29 дэх тал

цаашид үргэлжлүүлэх эсэх шаардлага нь тэдгээрийн үүрэг байх ёстой. Өвлөгдөх хөрөнгийн үнэ цэнийг хуваах зарчим нь зөвхөн гэрээгээр зохицуулах харилцаагаар хязгаарлагдахгүй бөгөөд хуульд зааснаар өвлөх, гэрээслэлээс үлдэх хэсгийг хуульд зааснаар өвлөх харилцаанд үйлчлэх бүрэн боломжтой.

VI. Дүгнэлт

Монгол Улс 1992 оны Үндсэн хуулиар өмчийн эрхийг тунхаглаж, түүнтэй холбогдох өв залгамжлал бодитоор хэрэгжих эрх зүйн зохицуулалтыг 2002 онд Иргэний хуульд тусган өгч, түүнээс хойш ямар нэгэн нэмэлт, өөрчлөлтгүйгээр өнөөдрийг хүржээ. Өв залгамжлуулж буй эд хөрөнгө, өвлүүлж буй бүх эд зүйлсийг өв хөрөнгө гэх бөгөөд уг хөрөнгөө хуульд заасан арга, хэлбэрээр бусдад шилжүүлж буй харилцаа нь өв залгамжлалын харилцаа болно. Өвлөгдөх хөрөнгө нь зөвхөн өв залгамжлалын харилцаанд л яригдах асуудал бөгөөд өөр бусад эрх зүйн харилцаанд яригдах учиргүй юм.

Өв залгамжлалын эрх зүй нь Иргэний эрх зүйн салбар эрх зүй болохынхоо хувьд иргэний эрх зүйн суурь хэд хэдэн зарчим болон өв залгамжлалын эрх зүйн зарчмыг баримтлах бөгөөд эдгээр зарчмуудад тулгуурлан өвлөгдөх хөрөнгийг хуваарилна.

Монгол Улсын Иргэний хуулиар хуульд зааснаар болон гэрээслэлийн журмаар өвлөх аргыг тусгайлан зохицуулж өгсөн. Харин хуульд тогтсон нэршлээр оруулаагүй боловч практикт ач холбогдол бүхий бусад эвлэрүүлэн зуучлах, шүүхийн журмаар болон гэрээгээр өвлөгдөх хөрөнгийг хуваарилах аргууд байна. Хуульд зааснаар өвлөх нь гэрээслэл үйлдээгүй тохиолдолд хууль ёсны өвлөгчид тогтсон дарааллын дагуу өв хөрөнгийг хуваарилах арга бол гэрээслэлээр өвлөх нь өвлүүлэгчийн хүсэл зоригийн дагуу өв хүлээн авагчид шилжүүлж буй үйлдэл юм. Манай Иргэний хууль дахь хуульд зааснаар болон гэрээслэлээр өвлөх арга нь БНСУ, Япон улсын Иргэний хууль дахь өвлөгдөх хөрөнгийг хуваарилах аргатай харьцуулахад төстэй байна.

Монгол Улсын иргэний хуульд өвлөгдөх хөрөнгийг хууль ёсны өвлөгчид өөрт ногдох хэсгийн талаар байгуулсан гэрээ нь хүчин төгөлдөр байхаар тусгасан бөгөөд энэхүү өгүүллээр өвлөгдөх хөрөнгийг гэрээний үндсэн дээр хуваарилах эрх зүйн зохицуулалтыг онол болон зарим улсын туршлагад үндэслэн шинэчлэхийг эрэлхийлсэн.

Монгол Улсад өв залгамжлалын эрх зүйн талаар судалгаа, бүтээл багагүй байх боловч өвлөгдөх хөрөнгийг гэрээгээр хуваарилах асуудлын талаар тусгайлсан судалгаа, бүтээл одоогоор байхгүй байна. Харин Иргэний хууль, иргэний эрх зүй болон өв залгамжлалын

эрх зүйн холбогдох зарчим, энэ чиглэлээр судалгаа хийдэг зарим судлаач нарын дэвшүүлсэн санал болон БНСУ, Япон Улсын харилцан тохиролцох замаар өвлөгдөх хөрөнгийг хуваарилдаг туршлага дээр үндэслэн Өвлөгдөх хөрөнгийг гэрээний үндсэн дээр хуваарилах аргыг дэвшүүлж байна.

Өвлөгдөх хөрөнгийг гэрээгээр хуваарилах харилцаа нь хууль ёсны өвлөгчид өөр хоорондоо харилцан тохиролцож өв хөрөнгийн биет байдал, өнөөгийн болон ирээдүйд олох үр шим, үр ашгийг харгалзан үзсэний үндсэн дээр түүний үнэ цэнийг алдагдуулахгүйгээр хуваах, хуваарилан авахтай холбогдсон харилцааг зохицуулах юм. Өв хөрөнгийн үнэ цэнийг харгалзан үздэг ойлголт манай улсын өв залгамжлалын эрх зүйн харилцаанд байдаггүй бөгөөд БНФУ нь өв залгамжлалын эрх зүйдээ “Өвлөгдөх хөрөнгийн үнэ цэнийг хуваах зарчим”-ын дагуу өв хөрөнгийн үнэ цэнийг хадгалах, хамгаалах замаар өв хөрөнгийг зохистой хуваарилах удирдамж оруулан хэрэгжүүлж байна. Уг зарчмын гол агуулга нь өв хөрөнгийн үнэ цэнийг чухалчлан авч үзэж, бодит, биет байдлаар хуваарилах явдлыг дэмжих юм. Тухайлбал, өв хөрөнгийг эн тэнцүү хуваах боломжгүй тохиолдолд гэрээний үндсэн дээр бусад өвлөгчдөд нөхөн төлбөр өгөх замаар харилцаагаа тэнцүүлэх, эсхүл аль нэг өвлөгчийн эзэмшилд шилжүүлэх замаар ирээдүйн ашгаас хүртэх, эсхүл өв хөрөнгийг хамтран эзэмшээд цааш үргэлжлүүлэх зэрэг өв хөрөнгийг биет байдлаар хуваарилахыг дэмжих туршлага юм.

Өвлөгдөх хөрөнгийг хуваарилах гэрээ нь өвийг бодитоор тусгаж, хууль ёсны өвлөгчдийг үнэн зөвөөр тодорхойлсон өвлөх эрхийн гэрчилгээ гарсны дараа хийгдэх бөгөөд хууль ёсны өвлөгчид өөр хоорондоо хэлэлцэн тохиролцож “Өвлөгдөх хөрөнгийн үнэ цэнийг хуваах зарчим”-ын дагуу өвийг хуваарилан авна. Өвлөгдөх хөрөнгийг хуваарилах гэрээгээр өв хөрөнгө, түүнтэй холбогдох эрх, үүрэг шилжих учир заавал нотариат, нотариатгүй газар баг, сумын Засаг даргаар гэрчлүүлэх шаардлагатай бөгөөд ийм хэлбэрийн шаардлага хангаагүй гэрээ нь хүчин төгөлдөр бус байна.

Энэхүү өгүүллийн үр дүнд иргэний хууль, иргэний эрх зүй болон өв залгамжлалын эрх зүйн холбогдох зарчим, энэ чиглэлийн зарим судлаач нарын дэвшүүлсэн санал болон БНСУ, Япон Улсын харилцан тохиролцох замаар өвлөгдөх хөрөнгийг хуваарилдаг туршлага, БНФУ-ын туршлага болох “Өвлөгдөх хөрөнгийн үнэ цэнийг хуваах зарчим”-д тулгуурлан өв хөрөнгийн үнэ цэнийг бууруулахгүйгээр өөр хоорондоо гэрээний үндсэн дээр хэлэлцэн тохиролцож өв хөрөнгийг хуваарилах боломжтой гэж үзлээ.

[Ном зүй]

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
- Монгол Улсын Иргэний хууль, 2002.
- Нотариатын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2011.
- Нотариатын үйлдэл хийх заавар, 2011.
- Т.Мөнхжаргал, Өв залгамжлалын эрх зүй, Улаанбаатар, 2009.
- Э.Байгаль, Иргэний эрх зүйн ерөнхий анги, Улаанбаатар, 2009.
- Д.Баярсайхан, Эрх зүйн онол, Улаанбаатар, 2010.
- Хууль зүйн яам, Иргэний эрх зүйн гарын авлага, Улаанбаатар, 2013.
- Б.Амарсанаа, Харьцуулсан эрх зүй судлал (хоёр дахь хэвлэл), Улаанбаатар, 2014.
- Б.Улаанбаатар, Монгол Улс дахь гэрээслэл: Асуудал, шинэчлэлт, Улаанбаатар, 2017.
- Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй (Олон улсын хувийн эрх зүйн хүрэн дэх судалгаа), Улаанбаатар, 2018.
- Орчуулагч Б.Урангоо, Япон улсын иргэний хуулийн орчуулга, Улаанбаатар, 2018.
- С.Должин. Хувийн эрх зүйн тайлбар толь бичиг. Улаанбаатар, 2019.
- Ж.Оюунтунгалаг. Иргэний эрх зүй I Ерөнхий анги. Улаанбаатар, 2020.
- Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Улаанбаатар, 2022.
- В.Оюумаа, “Өв залгамжлалын эрх зүйн харилцаанд нотариатчийн гүйцэтгэх үүрэг” «Өв залгамжлалын олон улсын эрх зүйн зохицуулалт» сэдэвт эрдэм шинжилгээ судалгааны семинар, 2007.
- Б.Улаанбаатар, “Өв залгамжлалын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага, хэтийн төлөв” Эрх зүй судлал сэтгүүл №2, 2016.
- Civil Code of the Republic of Korea, 1958.
- Civil Code of French Republic, 1804.
- Civil Code of Japan, 1896.
- Consulate General of the Republic of Korea in Los Angeles. Guide to Korean Law for Korean Americans (재미동포를 위한 한국법 가이드). Los Angeles: Consulate General of the Republic of Korea, 2011.
- “Héritage & Succession.” In Quand a lieu le partage d’une succession ? / Өвлөгдөх хөрөнгийг хэзээ хуваарилдаг вэ?/, 02 28 2024. <https://www.heritage-succession.com/article-quand-a-lieu-le-partage-dune-succession.html#:~:text=I1%20convient%20de%20pr%C3%A9ciser%20que,des%20droits%20dans%20une%20succession>
- “English lawyers Japan,” English lawyers Japan. <https://englishlawyersjapan.com/how-is-inheritance-divided-between-co-heirs-in-japan/>
- Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 210/МА2019/00568 дугаар магадлал https://shuukh.mn/single_case/12970?daterange=2019-01-01%20-%202019-11-10&id=2&court_cat=1&bb=1

[Abstract]

**Reforming the Legal Framework of Contractual
Distribution of Inheritance Property**

Erdenebat Otgontamir

Bachelor of Laws (LL.B)

Ulaanbaatar, Mongolia

Mongolia proclaimed property rights under the 1992 Constitution and incorporated the legal framework for inheritance into the Civil Code in 2002, which has remained unchanged to this day. The country has codified the methods of distributing inherited property both by law and by will in the Civil Code, while also ensuring that legal heirs have the right to allocate inherited property through agreements in an open and flexible manner. The contractual distribution of inherited property regulates the relations in which legal heirs mutually agree on the physical condition of the estate, its current and future benefits, and its value, ensuring that the property's worth is not diminished when divided and allocated. Since no specialized studies on this issue exist, this article introduces the contractual method of distributing inherited property based on the theories of civil law and inheritance law, scholarly perspectives, and comparative research on the practices of the Republic of Korea and Japan in distributing inherited estates by mutual agreement. Furthermore, this article examines the experience of the French Republic in preserving and transferring the value of inherited property and explores the possibilities of applying this approach to contractual inheritance distribution.

[Keywords]

Inheritance, inherited property, principle of dividing inherited property value, property division.